



МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2011 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 553

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Төлбөрийн картын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.


2.Дээрх журмыг 2011 оны 09 дүгээр сарын 27 -ны өдрөөс эхлэн мөрдөхийг Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан), оролцогч талуудад тус тус даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан 2011 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 216 дугаар тушаалын 1 дэх заалтыг 2011 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4.“Төлбөрийн картын журам”-ыг Монголбанкны цахим хуудсанд байршуулахыг Тамгын газар (Г.Цэрэнпүрэв)-т даалгасугай.

5.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан), Дотоод аудитын газар (Г.Тогтохбаатар)-т тус тус даалгасугай.

ТЭРГҮҮН ДЭД  
ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЖАВХЛАН

## ТӨЛБӨРИЙН КАРТЫН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу төлбөрийн карттай холбоотой үйл ажиллагааны зарчмуудыг тогтоох, картын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, төлбөрийн картын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавихад оршино.
- 1.2 Картаар банк хооронд төлбөр тооцоо хийх, Монголбанкнаас картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгоход Иргэний хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, энэхүү журам, Монголбанкнаас гаргасан бусад журмыг удирдлага болгоно.
- 1.3 Картын үйл ажиллагаанд оролцогч талууд нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох үүрэг хүлээж, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллана.
- 1.4 Картын үйл ажиллагаанд оролцогч талууд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр картаар хийгдэх санхүүгийн гүйлгээг төгрөгөөр гүйцэтгэнэ.

### ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1 Энэхүү журамд хэрэглэгдэх нэр томьёог дор дурьдсан утгаар ойлгоно:
  1. “Карт” гэж Монголбанкнаас картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан хуулийн этгээдээс төлбөр тооцоо хийхэд зориулж харилцагчид нээсэн бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн картын байгууллагын төлбөрийн картын стандартыг хангасан төлбөрийн картыг;
  2. “Карт гаргагчийг таних дугаар” (цаашид “БИН” гэх) гэж картын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг тодорхойлж, бусдаас ялгах үүрэгтэй, олон улсын картын байгууллагаас өөрийн гишүүн байгууллагадаа оноосон, эсвэл тухайн картын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээс тогтоосон картын дугаарын хэсэг болох тоон цуваа дарааллыг;
  3. “Картын гүйлгээ” гэж картаар хийгдэх энэ журмын 2.1.8, 2.1.9-д заасан санхүүгийн гүйлгээ болон санхүүгийн бус гүйлгээг;
  4. “Автомат теллер машин” (цаашид “АТМ” гэх) гэж 2.1.24, 2.1.25-д тодорхойлсон шууд болон шууд бус оролцогч байгууллагын суурилуулсан, картаар идэвхжиж өөрөө өөртөө үйлчлэх зарчмаар үйлдэл хийдэг цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжийг;
  5. “АТМ-ийн гүйлгээ” гэж АТМ-аар хийгдэх дараахь гүйлгээг:

- а) картын дансны бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ;
  - б) санхүүгийн бус гүйлгээ;
  - в) олон улсын стандарт болон энэ журмын 2.1.36-д тодорхойлсон сүлжээний дүрэмд нийцсэн бусад гүйлгээ.
6. “Бэлэн мөнгөний орлогын машин” - (*цаашид “БМОМ” гэх*) гэж 2.1.24, 2.1.25-д тодорхойлсон шууд болон шууд бус оролцогч байгууллагын суурилуулсан, өөрөө өөртөө үйлчлэх бэлэн мөнгөний орлогын болон төлбөрийн гүйлгээ хийх зориулалт бүхий цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжийг;
  7. “Хувийн таних дугаар” (*цаашид “ПИН код” гэх*) гэж картын гүйлгээ хийх зорилгоор карт эзэмшигчийн сонгосон тоон цуваа дарааллыг;
  8. “Санхүүгийн гүйлгээ” гэж карт эзэмшигч нь терминал, цахим мэдээ үүсгэгч ашиглан гүйцэтгэж байгаа мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх үйлдлийг;
  9. “Санхүүгийн бус гүйлгээ” гэж карт эзэмшигч нь терминал ашиглан дансны үлдэгдэл шалгах, ПИН кодыг өөрчлөх, гүйлгээний хуулга авах зэрэг мөнгөн дүнгээр үл илэрхийлэгдэх үйлдлийг;
  10. “Терминал” гэж 2.1.14-т тодорхойлсон ПОС терминал болон 2.1.17 -д тодорхойлсон банкны терминалыг;
  11. “Санхүүгийн дундын сүлжээ” (*цаашид “СДС” гэх*) гэж Монголбанк, арилжааны банк, Сангийн яамны Төрийн сангийн газрын цахим мэдээллийг дамжуулах свитчийн зорилгоор ажиллуулж буй компьютер, техник, програм хангамж, холбооны болон холболтын тоног төхөөрөмжөөс бүрдсэн сүлжээг;
  12. “ПОБ терминал” гэж шууд болон шууд бус оролцогчоос өөрийн салбар, нэгжид байршуулж үйл ажиллагааг хянадаг, картаар идэвхжиж үйлдэл хийдэг цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжийг;
  13. “ПОБ-ын гүйлгээ” гэж карт эзэмшигчээс ПОБ терминалаар хийгдэх дараахь гүйлгээг:
    - а) картын дансны бэлэн мөнгөний орлого, зарлагын гүйлгээ;
    - б) санхүүгийн бус гүйлгээ;
    - в) олон улсын стандарт болон энэ журмын 2.1.36-д тодорхойлсон сүлжээний дүрэмд нийцсэн бусад гүйлгээ.
  14. “ПОС терминал” гэж шууд болон шууд бус оролцогчоос гаргасан картаар үйлчлэх худалдаа үйлчилгээний цэгүүдэд суурилуулсан, төлбөр тооцоо хийх зориулалттай, картаар идэвхжиж үйлдэл хийдэг цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжийг;
  15. “ПОС-ын гүйлгээ” гэж карт эзэмшигчийн картаар ПОС терминал ашиглаж худалдан авалтын гүйлгээ болон уг гүйлгээний буцаалт хийхийг;
  16. “Процессор” гэж техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, програм хангамжийн үйлчилгээг картын үйл ажиллагаанд оролцогч талын карт гаргах, карт хүлээн авах үйл ажиллагаанд үзүүлж буй оролцогч талыг;
  17. “Банкны терминал” гэж ПОБ терминал, АТМ болон БМОМ;

18. “Цахим мэдээ” гэж картын гүйлгээний цахим хэлбэрийг;
19. “Цахим мэдээ үүсгэгч” гэж карт, картын дугаар, тусгай кодын тусламжтайгаар терминалаас бусад картын гүйлгээ үүсгэгч цахим төхөөрөмж, програм хангамжийг;
20. “Эквайрингийн сүлжээ” гэж хүлээн авагчийн техник, технологийн боломж, онцлогоос хамааран:
  - а) терминал, цахим мэдээ үүсгэгч;
  - б) Систем;
  - в) Програм хангамж, тоног төхөөрөмж;
  - г) Сүлжээ гэсэн хэсгүүдээс бүрдсэн байж болох цогц сүлжээ.
21. “Эквайрингийн үйлчилгээ/үйл ажиллагаа” гэж аль нэг картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн эквайрингийн сүлжээнд төлбөрийн карт хүлээн авч, холбогдох картын үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг;
22. “Карт гаргагч” гэж тухайн төлбөрийн картыг өөрийн харилцагчиддаа олгосон, Монголбанкнаас картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байгууллагыг;
23. “Карт хүлээн авагч” гэж тухайн төлбөрийн картыг өөрийн эквайрингийн сүлжээнд төлбөрт хүлээн авч, картын холбогдох үйлчилгээг үзүүлж буй Монголбанкнаас картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байгууллагыг;
24. “Шууд оролцогч гишүүн” гэж карт гаргах, банкны терминал, ПОС терминал, гар утас, бусад цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжийг эзэмших, түрээслүүлэх хэлбэрээр нийтэд үйлчилж, картын гүйлгээний боловсруулалт хийх байгууллагыг;
25. “Шууд бус оролцогч гишүүн” гэж карт гаргах, банкны терминал, ПОС терминал, гар утас, бусад цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжийг эзэмших, түрээслэх хэлбэрээр нийтэд үйлчилж, шууд оролцогч гишүүнээр дамжуулан картын гүйлгээний боловсруулалт хийх байгууллагыг;
26. “Гүйлгээний зөвшөөрөл” гэж картын гүйлгээ хийх зөвшөөрөл олгох болон татгалзах талаарх карт гаргагч байгууллагын үйл ажиллагааны цахим мэдээг;
27. “Гүйлгээний эрх олгох” гэж карт эзэмшигчээс тухайн гүйлгээ, төлбөрийг хүлээн зөвшөөрч, ПИН кодоо оруулах эсхүл гарын үсгээ зурж баталгаажуулахыг;
28. “Гүйлгээний боловсруулалт” гэж картын гүйлгээ, түүний төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотойгоор тусгай програм хангамжийг ашиглан карт хүлээн авагч, гаргагч болон свитчийн хооронд хийгдэж байгаа ажиллагааг;
29. “Данс” гэж карт эзэмшигчийн нэрийн өмнөөс карт гаргагч байгууллагын хөтөлж буй картын дансыг;
30. “Ажлын өдөр” гэж хуульд заасан нийтээр амрах баярын болон амралтын өдрөөс бусад өдрийг;
31. “КҮБ” гэж бараа үйлчилгээний төлбөрийг карт болон цахим мэдээ үүсгэгчийг ашиглан банкны харилцах дансаар хүлээн авдаг хуулийн этгээдийг;

32. “КҮБ-ийн шимтгэл” гэж Карт хүлээн авагч нь бараа үйлчилгээний төлбөрийг банкин дахь харилцах дансаар хүлээн авсны төлөө КҮБ-аас авч буй шимтгэлийг;
33. “КҮБ-ээс бэлэн мөнгө авах үйлчилгээ” (*цаашид “Кэшбэк” гэх*) гэж Карт эзэмшигч нь КҮБ-ээс бараа, үйлчилгээний хамт тодорхой хэмжээний бэлэн мөнгө авах үйлчилгээг;
34. “Свитч” гэж банк хооронд төлбөрийн картын гүйлгээг Монгол улсын нутаг дэвсгэр дээр хийх тусгай зөвшөөрлийг Монголбанкнаас авсан байгууллагыг;
35. “Свитчийн шимтгэл” гэж Свитч банк хоорондын гүйлгээ хийсний төлбөрт карт гаргагч болон карт хүлээн авагчаас авч буй шимтгэлийг;
36. “Сүлжээний дүрэм” гэж свитчийн ажиллуулж буй банк хоорондын картын гүйлгээний системд холбогдоход ашиглагдах техник технологийн стандарт болон хамтран ажиллах гэрээг;
37. “Хулгайн гүйлгээ” гэж бусдын өмчлөлд байгаа эд хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд санаатайгаар, шунахайн зорилгоор, нууцаар өөрийн эзэмшилд оруулах гүйлгээг;
38. “Залилан мэхлэх гүйлгээ” гэж бусдын өмчлөлд байгаа эд хөрөнгийг эзэмших, захиран зарцуулах эрхгүй этгээд итгэл эвдэх буюу хуурч мэхлэх аргаар, санаатайгаар, шунахай зорилгоор өөрийн эзэмшилд оруулах гүйлгээг.
39. “Уламжлалт унших арга” гэж картын цахим мэдээллийг авах зорилгоор картыг цахим мэдээ үүсгэгчийн зориулалт бүхий зайнд хийх, татаж уншуулах аргыг;
40. “Зайн унших арга” гэж картын цахим мэдээллийг авах зорилгоор картыг мэдээ үүсгэгч руу тодорхой зайнд ойртуулан уншуулах аргыг;
41. “Үндэсний брэнд төлбөрийн карт” (*цаашид “Үндэсний карт” гэх*) гэж Монголбанкны тогтоосон стандартын дагуу гаргасан дотоодын болон олон улсын төлбөр тооцоонд ашиглагдах төлбөрийн картыг;
42. “Залруулгын гүйлгээ” гэж карт хүлээн авагч банкнаас банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний үр дүнгийн тооцооллын зөрүүг гаргах, маргаантай гүйлгээ шийдвэрлэгдсэний үндсэн дээр банк хоорондын хийгдэх гүйлгээг;
43. “Эзэмшигчийн нэр бичигдээгүй карт” гэж үндэсний карт, мастер карт, виза карт болон бусад картын нүүрэн талд карт эзэмшигчийн хувийн мэдээлэл байрлахгүй картыг;
44. “Хосолсон ₮ карт” гэж карт гаргагч банкны олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран гаргасан, тухайн олон улсын байгууллагын эквайрингийн сүлжээнд хүлээн авах боломжтой картыг;

*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-219 дүгээр тушаалаар нэмсэн/](#)*

- 2.2 Энэхүү журамд хэрэглэгдэх монгол нэр томъёог 1 дүгээр хавсралтад заасны дагуу англи утгаар ойлгоно.

## ГУРАВ. КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

- 3.1 Картын үйл ажиллагаанд оролцогч талууд Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авч дараахь үйл ажиллагаа эрхэлж болно:

1. Карт гаргах үйл ажиллагаа;
  2. Карт хүлээн авах үйл ажиллагаа;
  3. Банк хооронд төлбөрийн картын гүйлгээ хийх үйл ажиллагаа;
- 3.2 Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь карт гаргах үүрэг хүлээнэ.
- 3.3 Карт нь эзэмшигчийн хандаж байгаа данснаас хамаарч дараахь төрөлтэй байж болно:
1. Карт эзэмшигчийн харилцах, хадгаламжийн данс руу шууд хандах боломжтой дебет карт;
  2. Карт гаргагчаас карт эзэмшигчид урьдчилан тохирч олгосон зээлийн эрхийн дагуу төлбөр гүйцэтгэх боломжтой кредит карт;
  3. Карт эзэмшигч нь тусгай зориулалтаар мөнгөн хөрөнгийг урьдчилан тусгаарласан данс руу шууд хандах боломжтой урьдчилсан төлбөрт карт;
  4. Төлбөрийн карт эзэмшигчийн хувийн мэдээллийг картын нүүрэн талд байрлуулахгүй буюу эзэмшигчийн нэр бичигдээгүй карт гаргаж болно;
  5. Хүний хөгжил сангаас хүүхдэд олгосон мөнгө байршсан данс руу шууд хандах боломжтой хүүхдийн ₮ дебет карт.
- [/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А-6 дугаар тушаалаар нэмсэн/](#)*
- 3.4 Карт нь цахим төхөөрөмж дээр уншигдах аргаас хамаарч дараахь төрөлтэй байж болно:
1. Уламжлалт карт;
  2. Зайн карт.
- 3.5 Карт нь хэрэглэгдэх байдлаасаа хамааран дараахь төрөлтэй байж болно:
3. Биет;
  4. Биет бус.
- 3.6 Карт нь дор дурьдсан үндсэн мэдээллийг агуулна:
1. Дебит болон кредит карт:
    - а) Карт гаргагчийн нэр, картын таних тэмдэг /лого/, эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн картын таних тэмдэг /лого/;
    - б) Карт эзэмшигчийн нэр/байгууллагын нэр
    - в) Свитчээс олгосон/бүртгүүлсэн БИН;
    - г) Картын дуусах хугацаа;
    - д) Карт гаргагчийн хаяг, холбоо барих утас, факсын дугаар, цахим шуудангийн хаяг;
    - е) Карт эзэмшигчийн гарын үсэг байрлах хэсэг.
  2. Урьдчилсан төлбөрт карт:
    - а) Карт гаргагчийн нэр, картын таних тэмдэг /лого/, эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн картын таних тэмдэг /лого/;

- б) Свитчээс олгосон/бүртгүүлсэн БИН;
  - в) Картын дуусах хугацаа;
  - г) Карт гаргагчийн хаяг, холбоо барих утас, факсын дугаар, цахим шуудангийн хаяг;
  - д) Карт эзэмшигчийн гарын үсэг байрлах хэсэг.
3. Зайн карт:
- а) Картын таних тэмдэг/лого/, эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн картын таних тэмдэг/лого/;
  - б) Карт гаргагчийн хаяг, холбоо барих утас, факсын дугаар, цахим шуудангийн хаяг.
- 3.7 Картаар дараахь үндсэн ба нэмэлт гүйлгээг хийнэ:
1. Үндсэн гүйлгээ:
- а) Банкны терминалын тусламжтайгаар данснаас бэлэн мөнгөний зарлагын гүйлгээ хийх;
  - б) Банкны терминалын тусламжтайгаар дансны үлдэгдэл шалгах;
  - в) ПОБ терминалын тусламжтайгаар бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийх;
  - г) ПОС терминалын тусламжтайгаар төлбөрийн гүйлгээ хийх, буцаах гүйлгээ хийх;
  - д) Гүйлгээний зөвшөөрөл авах;
  - е) ПОС терминалын тусламжтайгаар гүйлгээний урьдчилсан зөвшөөрөл авах;
  - ж) Банкны терминалын тусламжтайгаар ПИН код солих.
  - з) Банкны терминалын тусламжтайгаар буцаалт болон хэсэгчилсэн буцаалтын гүйлгээг хийх;
  - и) Картын гүйлгээний залруулга хийх;
  - к) БМОМ-ны тусламжтайгаар бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийх;
2. Нэмэлт гүйлгээ:
- а) ПОС терминалын тусламжтайгаар дансны үлдэгдлийг шалгах;
  - б) АТМ-ын тусламжтайгаар бэлэн мөнгөний орлогын гүйлгээ хийх;
  - в) Банкны терминалын тусламжтайгаар төлбөр хийх;
  - г) Цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээ хийх;
  - д) олон улсын стандарт болон свитчийн сүлжээний дүрэмд зохицсон бусад гүйлгээ.
- 3.8 Карт хүлээн авагч нь энэхүү журмын 3.7.1-д заасан дараахь картын гүйлгээг банк хоорондын свитчийн сүлжээгээр дамжуулан гүйцэтгэнэ:
- 1. шууд болон шууд бус оролцогч гишүүний гаргасан дотоодын карт;
  - 2. олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн карт гаргагч байгууллагын гишүүн болж дотоодын карт гаргагчийн гаргасан бүх төрлийн карт;

3. гадаадын карт гаргагчийн гаргасан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн карт;
4. бүх төрлийн биет болон биет бус карт;
5. урьдчилсан төлбөрт карт.
6. уламжлалт аргаар уншигддаг бүх төрлийн төлбөрийн карт;

3.9 Картын үйл ажиллагаанд дараахь талууд оролцоно:

1. Энэхүү журмын 3.3, 3.4, 3.5-т заасан картыг олон нийтэд тарааж, карт эзэмшигчтэй төлбөр тооцоо хийх үүрэг бүхий карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкнаас авсан, шууд болон шууд бус оролцогч гишүүд (цаашид “карт гаргагч” гэх);
2. Карт эзэмшигчийн картыг терминал, цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар үйлчилж КҮБ-тай төлбөр тооцоо хийх үүрэг бүхий карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрлийг Монголбанкнаас авсан, шууд болон шууд бус оролцогч гишүүд (цаашид “карт хүлээн авагч” гэх);
3. Картаар өөрийн данс руу хандах эрх бүхий хувь хүмүүс, аж ахуйн нэгж, байгууллагууд (цаашид “карт эзэмшигч” гэх);
4. ПОС терминал, цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар бараа, үйлчилгээний төлбөрийг картаар дамжуулан өөрийн банкны данс руу хүлээн авах боломж бүхий картаар үйлчлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд (цаашид “КҮБ” гэх);
5. Банк хооронд төлбөрийн картын гүйлгээг Монгол улсын нутаг дэвсгэр дээр хийх тусгай зөвшөөрлийг Монголбанкнаас авсан байгууллага (цаашид “Свитч” гэх);
6. Процессор.

~~3.10 Монголбанк нь Монгол Улсад мөрдөгдөх төлбөрийн картын үйл ажиллагаатай холбоотой стандартыг тогтооно.~~

~~*/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн А-105 дугаар тушаалаар хассан/*~~

- ~~1. Карт хүлээн авагч банк нь ПОС терминалыг карт уншуулах үеэс эхлэн зөвшөөрөл олгосон хариуг хүлээн авах хүртэлх үе шат бүрт 20 (хорин) секундээс илүү хугацаа зарцуулах нөхцөлд автоматаар анхны төлөвт шилжиж, дараагийн төлбөрийн картыг хүлээн авахад бэлэн байхаар програмчлах.~~

~~*/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн А-105 дугаар тушаалаар хассан/*~~

## ДӨРӨВ. КАРТ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

4.1 Карт гаргагч дараахь шаардлагыг хангасан байна:

1. Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх;
2. Үр дүнгийн тооцоо хийх зориулалт бүхий дансыг Монголбанкинд нээсэн байх;
3. Төлбөрийн карт гаргах зөвшөөрлийг энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас авсан байх;
4. Мэргэжлийн тусламж дэмжлэг үзүүлэх чадвартай боловсон хүчнээс бүрдсэн картын үйлчилгээ үзүүлэх тусгай нэгж, газар хэлтэстэй байх.

#### 4.2 Карт гаргагч дараахь үүрэгтэй:

1. Карт гаргах зөвшөөрлийг Монголбанкнаас авсан өдрөөс 6 сарын дотор тухайн картыг аль нэг свитчийн сүлжээгээр үйлчлүүлэх боломжоор хангах.
2. Төлбөрийн картын тусламжтайгаар олгосон бүх төрлийн зээлийн тухай мэдээллийг Зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх.
3. Карт эзэмшигчийн өмнө:
  - а) Картын үйлчилгээний нөхцөлийг тодорхой заасан гэрээг карт эзэмшигчтэй байгуулах;
  - б) Гүйлгээний зөвшөөрөл олгох болон гүйлгээний боловсруулалтыг тасралтгүй үзүүлэх;
  - в) Хувийн нууцад хамаарах мэдээллийг хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад зориулалтаар ашиглахгүй байх;
  - г) ПИН кодыг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусдад мэдээлэхгүй байх;
  - д) Картыг шинээр олгохдоо шуудан, интернет, гар утас болон бусад холбооны хэрэгслээр дамжуулан олгож байгаа тохиолдолд карт эзэмшигчид карт болон ПИН кодыг тус тусад нь хүлээлгэн өгөх;
  - е) Карт эзэмшигч картыг хүлээж авсан буюу хүлээн авснаа мэдэгдсэнээс хойш идэвхжүүлж байх;
  - ж) Карт, ПИН код алдагдсан нь эзэмшигчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан эсэхээс үл хамааран энэ журмын 4.4.10-д заасан мэдэгдлийг хүлээн авсан даруй гүйлгээний эрхийг хааж, цаашдын алдагдлаас сэргийлэх;
  - з) Карт эзэмшигчийн мэдэгдлийн дагуу авах арга хэмжээг тодорхой тусгасан журамтай байх, түүнийг карт эзэмшигчид танилцуулах, мэдэгдлийн хариуг гэрээнд заасан хоногт багтаан өгөх;
  - и) Карт эзэмшигчийн данс руу орлогын болон зарлагын гүйлгээг ПОБ терминалын тусламжтайгаар хийх үйлчилгээг өөрийн бүх салбар, тооцооны нэгжээр үзүүлэх;
  - к) Хүүхдийн мөнгийг картаар авах хүсэлтэй иргэнд "Ирээдүй" хүүхдийн ₮ картыг үнэ төлбөргүй олгоно.

[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А-6 дугаар тушаалаар нэмсэн/](#)

#### 4. Карт хүлээн авагчийн өмнө:

- а) Сэжигтэй картын талаарх мэдээллээр хангах;
- б) Карт гаргагч нь карт эзэмшигчээс 4.4.10-г заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш хуурамч болон залилан мэхлэх шинжтэй гүйлгээ хийх зөвшөөрлийг өгснөөс үүсэх хохирлыг хариуцах;
- в) Карт гаргагчийн үүсгэсэн маргааныг хамтран ажиллах гэрээнд заасны дагуу шийдвэрлэх;
- г) Свитчийн тогтоосон КУБ-н шимтгэлийг хуваах зарчмын дагуу төлөх.

5. Свитчийн өмнө:

- а) Хамтран ажиллах гэрээ байгуулах, түүнийг даган мөрдөх.
- б) Свитчийн тогтоосон КҮБ-ын шимтгэлийн хуваах зарчмыг даган мөрдөх;
- в) Свитчээр дамжин шийдвэрлэгдэж буй маргааныг дор бүр нь судалж, гэрээнд заасан хоногт багтаан шийдвэрлэх
- г) Картын БИН-ийг бүртгүүлэх;
- д) Свитчийн гүйлгээнд хамтран ажиллах гэрээнд заасан хугацааны дотор хариу өгөх.

4.3 Карт гаргагч нь энэ журмын 3.3, 3.4, 3.5-т заасан картыг гаргах эрхтэй.

4.4 Карт гаргагч нь карт эзэмшигчтэй байгуулсан гэрээнд дараахь зүйлийг тусгана:

1. Тухайн төлбөрийн картын тодорхойлолт, ашиглаж болох терминал, хэрэгслийн техникийн шаардлага, ашиглах арга, гүйцэтгэж болох үйлдлийн төрөл, гүйлгээний үнийн дүнгийн болон давтамжийн хязгаарлалт байгаа бол түүнийг;
2. Карт гаргагч, хүлээн авагч банк болон эзэмшигчийн эрх үүрэг, хариуцлага;
3. Карт эзэмшигчийн данснаас дебит болон кредит төлбөрийн гүйлгээ хийгдэх хугацааны талаарх мэдээлэл;
4. Төлбөрийн картыг ашиглахтай холбогдсон үйлчилгээний хөлс, хураамж байх бол түүнийг:
  - а) Элсэлтийн болон жилийн хураамжийн хэмжээ;
  - б) Гүйлгээний шимтгэлийн төрөл, хэмжээ;
  - в) Хүүгийн хэмжээ болон хүү тооцох журам.
5. Эзэмшигчээс эрх олгогдоогүй гүйлгээг залруулахыг шаардах хугацааны хязгаар, шаардлага гаргах хэлбэр, журам;
6. Төлбөрийн карт нь гадаадад ашиглах эрхтэй бол гадаад валютаар хийгдэх гүйлгээний шимтгэл, хураамж болон төгрөгт хөрвүүлэх ханш, түүнийг хэрэглэх журам, хугацаа, хүүгийн хэмжээ;
7. Карт гаргагч болон хүлээн авагч нь хуанлийн 30 /гуч/-аас доошгүй хоногийн өмнө гэрээнд өөрчлөлт оруулах талаар тухайн харилцагчид мэдэгдсэнээр гэрээний нөхцөлийг өөрчлөх эрхтэй. Мэдэгдэлд заасан хугацаанд эзэмшигч гэрээнээс татгалзаагүй бол, гэрээний нөхцөлийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцох тухай;
8. Зээлийн хүүгийн өөрчлөлт нь нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд карт гаргагч нь энэ талаарх мэдээлэл эзэмшигчид нэн даруй мэдэгдэх тухай;
9. Дараахь зүйлсийг гэрээнд зайлшгүй тусгана:
  - а) карт гээсэн тохиолдолд мэдэгдэх;
  - б) гэрээгээр заасан үүргээ хүлээх;
  - в) картыг бусдад ашиглуулахгүй байх;

- г) ПИН кодоо нууцлах;
10. Эзэмшигч нь дараахь тохиолдлыг карт гаргагчид нэн даруй мэдэгдэх:
- а) төлбөрийн карт буюу түүнийг идэвхжүүлэх ПИН кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсаныг;
  - б) өөрийн дансанд эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн тухай мэдсэнийг;
  - в) тухайн карт гаргагч банкин дахь өөрийн данстай холбоотой бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлснийг;
  - г) өөрийн ПИН болон бусад кодыг эрх олгогдоогүй гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй тухай сэжиглэснийг.
- 4.5 Карт эзэмшигч 4.4.10-д заасан мэдэгдлийг өөрийн биеэр, бичгээр, утсаар өгч болно. Карт гаргагч нь бодит нөхцөл байдалд үндэслэн эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн, хийгдэж болзошгүйг мэдэгдсэн үеэс эхлэн энэ зүйлд заасан мэдэгдлийг авсанд тооцно.
- 4.6 Карт гаргагч нь гүйлгээний боловсруулалтаа процессороор хийлгэж байгаа тохиолдолд процессорт санхүүгийн баталгаа гаргана.

#### ТАВ. КАРТ ХҮЛЭЭН АВАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

- 5.1 Карт хүлээн авагч дараахь шаардлагыг хангасан байна:
- 1. Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх;
  - 2. Үр дүнгийн тооцоо хийх зориулалт бүхий дансыг Монголбанкинд нээсэн байх;
  - 3. Карт хүлээн авах зөвшөөрлийг энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас авсан байх;
  - 4. Мэргэжлийн тусламж дэмжлэг үзүүлэх чадвартай боловсон хүчнээс бүрдсэн картын үйлчилгээ үзүүлэх тусгай газар хэлтэстэй байх.
- 5.2 Карт хүлээн авагч дараахь үүрэгтэй:
- 1. Карт эзэмшигчийн өмнө энэ журмын 3.7-т заасан картын үндсэн болон нэмэлт гүйлгээг хийх боломжийг карт эзэмшигчид олгох.
  - 2. Карт гаргагчийн өмнө:
    - а) КУБ нь карт эзэмшигчийн гарын үсгийг шалгаагүй, картын эзэмшлийг тодорхойлоогүйгээс бусад тохиолдлоор гарсан хуурамч болон залилан мэхлэх шинжтэй гүйлгээнээс үүсэх хохирлыг хариуцах;
    - б) Карт гаргагчийн үүсгэсэн маргааныг дор бүр нь судалж, гэрээнд заасан хугацаанд шийдвэрлэх;
    - в) Карт гаргагчийн гүйлгээнд хамтран ажиллах гэрээнд заасан хугацааны дотор хариу өгөх;
    - г) Свитчийн тогтоосон КУБ-н шимтгэлийг хуваах зарчмын дагуу төлөх.
  - 3. КУБ-ын өмнө:

- а) Картын үйлчилгээний нөхцөлийг тодорхой заасан гэрээ байгуулах;
  - б) КҮБ-д тавигдах шаардлагыг хангуулж, хяналт тавих;
  - в) КҮБ дээр тавигдсан терминалын тохиргоонд тухайн КҮБ-ын хаягийг “Монгол улсын бүсчлэлийн стандарт”-ын дагуу бүртгэж, үнэн зөв оруулах;
  - г) КҮБ-ын картын төлбөр тооцоотой холбоотой үйл ажиллагааг хянах;
  - д) КҮБ-ыг ПОС терминал дээр ажиллаж сургах;
  - е) КҮБ-тай 1 сарын дотор тооцоо хийх;
  - ж) Хуурамч болон залилан мэхлэх шинжтэй гүйлгээ илрүүлсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авах;
  - з) КҮБ-ын үүсгэсэн маргааныг дор бүр нь судалж, гэрээнд заасан хугацаанд шийдвэрлэх;
  - и) КҮБ-ын гүйлгээнд хамтран ажиллах гэрээнд заасан хугацааны дотор хариу өгөх.
4. Свитчийн өмнө:
- а) Хамтран ажиллах гэрээ байгуулах, түүнийг даган мөрдөх.
  - б) Свитчийн тогтоосон КҮБ-н шимтгэлийн хуваах зарчмыг даган мөрдөх;
  - в) Свитчээр дамжин шийдвэрлэгдэж буй маргааныг дор бүр нь судалж, гэрээнд заасан хугацаанд шийдвэрлэх;
  - г) БИН кодыг бүртгүүлэх;
5. "Ирээдүй" хүүхдийн ₮ картыг ашиглаж, архи, тамхи, согтууруулах ундааны болон шөнийн цэнгээний газарт төлбөр хийх боломжийг хязгаарлах.  
*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А-6 дугаар түшаалаар нэмсэн/](#)*
6. Энэ журмын 24 дүгээр хавсралтад заасны дагуу цахим мэдээ үүсгэгч төхөөрөмжид тавигдах шаардлагыг хангаж ажиллах.  
*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн А-105 дугаар түшаалаар нэмсэн/](#)*
- 5.3 Карт хүлээн авагч нь гүйлгээний боловсруулалтаа процессороор хийлгэж байгаа тохиолдолд процессорт санхүүгийн баталгаа гаргана.
- 5.4 Банкны терминалыг Монголбанкнаас хүлээн авагчийн зөвшөөрлийг авсан байгууллага суурилуулж, гүйлгээний боловсруулалтыг хийнэ.

## ЗУРГАА. СВИТЧИД ТАВИХ ШААРДЛАГА

- 6.1 Свитч дараахь шаардлагыг хангасан байна:
- 1. Банк хооронд картын гүйлгээний боловсруулалт хийх тусгай зөвшөөрлийг энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас авсан байх;
  - 2. Сүлжээний дүрмийг оролцогч тал болон Монголбанкаар хянуулахыг хүлээн зөвшөөрсөн байх;

3. Шууд болон шууд бус оролцогчийн үр дүнгийн тооцоог Монголбанкин дахь харилцах дансаар гүйцэтгэх боломжийг хангасан байх.
  4. Тухайн свитч өөрийн сүлжээндээ бүх оролцогч талуудад ижил хэмжээтэй шимтгэлийг тогтооно.
- 6.2 Свитч дараахь эрх үүрэгтэй:
1. Терминал, цахим мэдээ үүсгэгч, импринтерээр хийгдсэн картын гүйлгээг банк хооронд хийх боломжоор хангах;
  2. Банк хооронд картын гүйлгээний төлбөр тооцоог карт гаргагч, карт хүлээн авагчтай хийсэн гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;
  3. Шууд болон шууд бус оролцогч аль нэг талд үйлчилгээний давуу эрх олгохгүй байх;
  4. Банк хооронд картын гүйлгээний төлбөр тооцоог “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний журам” -д заасны дагуу гүйцэтгэх;
  5. Гүйлгээний боловсруулалтыг тасралтгүй хийх;
  6. Картын гүйлгээний нууцлалыг хангах;
  7. Сэжигтэй картын мэдээллийн санг хөтлөн ажиллуулж, карт гаргагч, хүлээн авагч болон свитчийн хүсэлтээр уг сангаас мэдээллийг гэрээний үндсэн дээр өгөх;
  8. Карт гаргагчийн өмнөөс гүйлгээний зөвшөөрлийг хүлээн авагчийн хүсэлтээр тусгай гэрээний үндсэн дээр олгох;
  9. Свитчийн шимтгэлийг карт гаргагч болон карт хүлээн авагчаас авах;
  10. Хамтран ажиллах гэрээ байгуулах, карт гаргагч болон хүлээн авагчаас гэрээний мөрдөлтийг шаардах;
  11. Залруулгын гүйлгээ хийх, картын гүйлгээний маргааныг шийдвэрлэх боломжоор хангах, хянах;
  12. Карт хүлээн авагчийн гүйлгээнд хамтран ажиллах гэрээнд заасан хугацааны дотор хариу өгөх.
- 6.3 Свитч нь өөрийн системд мөрдөх эрх зүй, техникийн бодлогыг свитчийн сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээний тусламжтайгаар хэрэгжүүлнэ.
- 6.4 Свитч нь өөрийн оролцогч талд системд мөрдөх эрх зүй, техникийн ижил шаардлага тавина.
- 6.5 Свитчийн сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд дараахь зүйлсийг заасан байна:
1. Оролцогч талын эрх, үүрэг;
  2. Свитчийн системд гишүүнээр элсэхэд тавигдах шаардлага;
  3. Свитчийн системд холбогдох техникийн стандарт;
  4. Свитчийн явуулах үйлчилгээний жагсаалт, тэдгээрийн дэлгэрэнгүй тайлбар;
  5. Свитчийн мөрдөх цахим мэдээний стандарт;
  6. Шимтгэлийн хэмжээ, тэдгээрийг хуваарилах зарчим;

7. Төлбөр тооцоо, үр дүнгийн тооцоо хийх давтамж;
  8. Маргаан шийдвэрлэх зарчим;
  9. Тасралтгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах аргачлал, тэдгээрийг хангаагүй тохиолдолд авах арга хэмжээ;
  10. Оролцогч талын байгуулах гэрээний загвар.
- 6.6 Свитч нь сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд орсон өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос ажлын 5 хоногийн өмнө оролцогч тал болон Монголбанкинд ирүүлнэ.
  - 6.7 Свитчийн сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээ нь оролцогч талд нээлттэй, ил тод байна.
  - 6.8 Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний маргааныг шийдвэрлэх зарчмыг свитч гаргаж, маргаанд оролцогч талуудын эрх, үүрэг, маргааныг шийдвэрлэх хугацааг сүлжээний дүрэм, хамтран ажиллах гэрээнд тодорхой тусгасан байна.
  - 6.9 Свитч нь маргаан шийдвэрлэх зарчмыг Монголбанкаар хянуулж оролцогч талд нээлттэй байлгана.
  - 6.10 Оролцогч тал нь свитчийн банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний маргааныг шийдвэрлэсэн байдалд гомдолтой бол энэ талаар Монголбанкинд хандаж болно.
  - 6.11 Свитч нь гүйлгээний боловсруулалтаа процессороор хийлгэж байгаа тохиолдолд процессорт санхүүгийн баталгаа гаргана.

#### ДОЛОО. КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭГЧ ГУРАВДАГЧ ЭТГЭЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА

- 7.1 Процессор нь дараахь шаардлагыг хангасан байна:
  1. Карт гаргагч, хүлээн авагч, свитчтэй гүйлгээний боловсруулалт хийх гэрээ байгуулсан байх;
  2. Мэргэжлийн тусламж дэмжлэг үзүүлэх чадвартай боловсон хүчнээс бүрдсэн тусгай нэгж (газар, хэлтэс, алба)-тай байх;
  3. Монголбанк болон олон улсын байгууллагаас шаардах стандартыг биелүүлэн ажиллах чадвартай байх;
  4. Энэхүү журмыг мөрдөн ажиллахыг хүлээн зөвшөөрсөн байх;
- 7.2 КУБ дараахь эрх үүрэгтэй:
  1. Карт хүлээн авагчаа өөрөө сонгох;
  2. Картыг бэлэн мөнгөний нэгэн адил төлбөрт хүлээн авах;
  3. Хүлээн авагчаас тавьсан гүйлгээний зөвшөөрөлтэй холбоотой шаардлагыг хангаж ажиллах;
  4. Бараа үйлчилгээний төлбөрийг банкин дахь харилцах дансаар хүлээн авах.

## НАЙМ. КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

- 8.1. Карт гаргах болон хүлээн авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь энэ журмын 8.9, 8.10-д заасан баримт бичгийг бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ.
- 8.2. Свитчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ журмын 8.11-д заасан баримт бичгийн бүрдүүлж Монголбанкинд ирүүлнэ.
- 8.3. Монголбанкны Төлбөр тооцоо, бүртгэлийн газар /цаашид “ТТБГ” гэх/ нь хүсэлт гаргагчаас баримт бичгийг бүрэн гүйцэд, үнэн зөв бүрдүүлж ирүүлснээс хойш холбогдох зөвшөөрөл олгох эсэх асуудлыг ажлын 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.
- 8.4. ТТБГ нь карт гаргах, бүртгэх, эзэмшигчид олгох, гүйлгээний боловсруулалт хийх зэрэг картын үйл ажиллагаа эрхлэхэд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг, эзэмшигчтэй байгуулах гэрээний төслийг хянаж, тухайн үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлүүдийг бууруулах, хянах бололцоотой эсэх байдалд дүгнэлт гаргана. Шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар Монголбанкны Хуулийн хэлтсээс дүгнэлт гаргуулна.
- 8.5. ТТБГ нь энэ журмын 8.4-д заасан дүгнэлтийг, шийдвэрийн төслийн хамт Монголбанкны Захирлуудын зөвлөл /цаашид 33 гэх/ - ийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 8.6. 33-ийн хуралдаан болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч зөвшөөрөл олгох эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ. Монголбанкаас зөвшөөрөл олгосон эсэх талаарх хариуг шийдвэр гарснаас хойш хүсэлт гаргагчид ажлын 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
- 8.7. Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг үндэслэн ТТБГ тухайн банкны зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийнэ.
- 8.8. Банкны тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актаар тавьсан шаардлагад нийцээгүй бол Монголбанк картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгохоос татгалзана.
- 8.9. Карт гаргах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь дор дурьдсан бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлж, эх хувийг Монголбанкинд ирүүлнэ.
  1. Карт гаргах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдлийг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу;
  2. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн карт гаргагч байгууллагын гишүүнээр элссэн тохиолдолд тухайн байгууллагын зөвшөөрөл;
  3. Техник тоног төхөөрөмж, програм хангамж, ажлын байрны тодорхойлолт; /Тодорхойлолтод техник тоног төхөөрөмж, програм хангамжийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, аюулгүй байдал, нууцлал, свитчийн сүлжээний дүрэмд тавьсан шаардлагад нийцэн ажиллах асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл байна/;
  4. Карт гаргах, бүртгэх, нийтэд тараах, гүйлгээний боловсруулалт хийх зэрэг картын үйл ажиллагаа эрхлэхэд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг /дүрэм, гэрээ гэх мэт/;
  5. Дараахь үйл ажиллагааг зохицуулсан журмыг:
    - а) Маргаан шийдвэрлэх;
    - б) Карт хэвлэх, карт эзэмшигчид олгох;

- в) Нууцлал;
  - г) Хоорондын тооцооны;
  - д) Картын үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
  - е) Эрсдэлийн удирдлагын;
  - ж) Бусад.
6. Картын үйл ажиллагааг хариуцах боловсон хүчний дэлгэрэнгүй анкет;
  7. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг хүлээн зөвшөөрсөн зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн ТУЗ-ийн тогтоол;
  8. Карт гаргах үйл ажиллагааны зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлсийг “Монголбанкны хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу төлсөн баримт;
  9. Карт гаргагч нь шууд бус оролцогч бол шууд оролцогчийн зөвшөөрөл.
- 8.10. Карт хүлээн авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь дор дурьдсан бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлж эх хувийг Монголбанкинд ирүүлнэ.
1. Карт хүлээн авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдлийг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу;
  2. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн карт хүлээн авагч байгууллагын гишүүнээр элссэн тохиолдолд тухайн байгууллагын зөвшөөрөл;
  3. Техник тоног төхөөрөмж, програм хангамж, ажлын байрны тодорхойлолт; /Тодорхойлолтод техник тоног төхөөрөмж, програм хангамжийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, аюулгүй байдал, нууцлал, свитчээс тавьсан шаардлагад нийцэн ажиллах асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл байна/;
  4. Үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, гэрээ;
  5. Дараахь үйл ажиллагааг зохицуулсан журмыг:
    - а) Маргаан шийдвэрлэх;
    - б) Нууцлал;
    - в) Хоорондын тооцооны;
    - г) Картын үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
    - д) Эрсдэлийн удирдлагын;
    - е) Бусад.
  6. Картын гүйлгээний боловсруулалт хийх системийн дэлгэрэнгүй тайлбар, системийн техникийн баримт бичиг, боловсруулсан компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл;
  7. Картын гүйлгээний боловсруулалтын системийн үйл ажиллагааг хариуцах боловсон хүчний дэлгэрэнгүй анкет; /Хэрэв тус үйлчилгээг гуравдагч этгээдээр хийлгэх тохиролцоонд хүрсэн бол байгуулсан үйлчилгээний гэрээ болон үйлчилгээ үзүүлэх байгууллагын дэлгэрэнгүй мэдээлэл/;

8. Банкны терминал, ПОС терминал болон бусад цахим мэдээ үүсгэгч электрон төхөөрөмжийн програмчлал, техникийн үйлчилгээ, сайжруулалт хариуцах боловсон хүчний дэлгэрэнгүй анкет /Хэрэв тус үйлчилгээг гуравдагч этгээдээр хийлгэх тохиролцоонд хүрсэн бол байгуулсан үйлчилгээний гэрээ болон үйлчилгээ үзүүлэх байгууллагын дэлгэрэнгүй мэдээлэл/;
  9. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг хүлээн зөвшөөрсөн зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн ТУЗ-ийн тогтоол;
  10. Карт хүлээн авах үйл ажиллагааны зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлсийг “Монголбанкны хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу төлсөн баримт;
  11. Карт хүлээн авах үйл ажиллагааг эрхлэхэд үүсч болох эрсдэлийг даах баталгаа.
- 8.11. Свитчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч нь дор дурьдсан бичиг баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлж эх хувийг Монголбанкинд ирүүлнэ.
1. Свитчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдлийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу;
  2. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн карт гаргагч байгууллагын гишүүнээр элссэн тохиолдолд тухайн байгууллагын зөвшөөрөл;
  3. Техник, тоног төхөөрөмж, програм хангамж, ажлын байрны тодорхойлолт; /Тодорхойлолтод техник тоног төхөөрөмж, програм хангамжийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, аюулгүй байдал, нууцлалын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл байна/;
  4. Свитчийн үйл ажиллагаа эрхлэхэд мөрдөх бодлогын болон эрх зүйн баримт бичиг /дүрэм, гэрээ гэх мэт/;
  5. Дараахь үйл ажиллагааг зохицуулсан журмыг:
    - а) Маргаан шийдвэрлэх;
    - б) Нууцлал;
    - в) Хоорондын тооцооны;
    - г) Картын үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
    - д) Эрсдэлийн удирдлагын;
    - д) бусад.
  6. Свитчийн үйл ажиллагааг хариуцах боловсон хүчний дэлгэрэнгүй анкет;
  7. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг хүлээн зөвшөөрсөн зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн ТУЗ-ийн тогтоол;
  8. Свитчийн үйл ажиллагааны зөвшөөрөл олгох үйлчилгээний хөлсийг “Монголбанкны хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн дагуу төлсөн баримт;
  9. Байгууллагын ТУЗ-өөр баталгаажуулсан эзэмшигчдийн жагсаалт, тэдгээрийн эзэмших хувийн тухай мэдээлэл.

- 8.12. Монголбанк дараахь үндэслэлээр банкны картын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно:
1. Карт эзэмшигч, КҮБ-ын төлбөрийн тооцоог гүйцэтгээгүй, удаа дараа саатуулсан, будлиантуулсан;
  2. Картын үйл ажиллагааны техникийн нууцлалыг зохих түвшинд хангаагүй;
  3. Свитчээс тавьсан шаардлагыг удаа дараа зөрчсөн эсвэл биелүүлэхээс татгалзсан тухай албан ёсны мэдэгдлийг свитчээс хүлээн авсан;
  4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.
- 8.13. Монголбанк дараахь үндэслэлээр свитчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно:
1. Карт эзэмшигч, КҮБ-ын төлбөрийн тооцоог гүйцэтгээгүй, удаа дараа саатуулсан, будлиантуулсан;
  2. Свитчийн үйл ажиллагааны техникийн нууцлалыг зохих түвшинд хангаагүй;
  3. Шууд болон шууд бус оролцогчдоос тавьсан шаардлагыг удаа дараа зөрчсөн эсвэл биелүүлэхээс татгалзсан тухай албан ёсны мэдэгдлийг хүлээн авсан;
  4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

## ЕС. КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ, ХҮҮ, ШИМТГЭЛ

- 9.1 Карт гаргагч дараахь шимтгэлийг авч болно:
1. Карт хэвлэх шимтгэл;
  2. Карт идэвхжүүлэх буюу тэдгээрт өөрчлөлт оруулах шимтгэл;
  3. Картын үйлчилгээний жилийн хураамж;
  4. Бусад.
- 9.2 Карт гаргагчийн картын тусламжтайгаар олгогдох зээлд тооцох хүүг картын шимтгэл гэж үзэхгүй.
- 9.3 Карт хүлээн авагч дараахь шимтгэлийг авч болно:
1. КҮБ-ын шимтгэл;
  2. Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний бэлэн мөнгөний шимтгэл (АТМ, ПОБ, кэшбэк, г.м үйлчилгээ);
  3. Бусад.
- 9.4 Свитч дараахь шимтгэлийг авч болно:
1. Гишүүнчлэлийн шимтгэл;
  2. Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний шимтгэл;
  3. Бусад.

- 9.5 Энэхүү журмын 9.3.1 дэх заалтад заасан шимтгэлийн дээд, доод хязгаарыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.
- 9.6 Свитч нь сүлжээнд оролцогч талуудтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр 9.3.1 болон 9.3.2-д заасан шимтгэлийг тогтооно.
- 9.7 Картын оролцогч талууд дараах байдлаар шимтгэлийн хуваах зарчмыг мөрдөнө:
1. Карт хүлээн авагч нь КҮБ-д хийгдсэн гүйлгээний дүнгийн 0.3 хувиас доошгүй хэмжээтэй шимтгэлийг карт гаргагчид төлөх;
- 9.8 Энэ журмын 9.3.1, 9.4.2 дахь заалтад заасан шимтгэлийг карт эзэмшигч төлөхгүй.
- 9.9 Свитч нь энэ журмын 9.4 дэх заалтад заасан шимтгэлийн хэмжээг өөрийн сүлжээний дүрэмд тодорхой заах үүрэгтэй бөгөөд оролцогч талуудаар зөвшөөрүүлсэн байна.

#### АРАВ. БАНК ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭНИЙ СУУРЬ ЗАРЧИМ

- 10.1 Банк хоорондын төлбөрийн картын терминалаар хийгдсэн гүйлгээ нь картын төрөл, хийгдэж буй гүйлгээний төрлөөс үл хамааран онлайн горимоор явагдана.
- 10.2 Карт хүлээн авагч нь карт гаргагч, свитчээс гүйлгээний зөвшөөрөл аваагүй тохиолдолд гүйлгээ хийхийг хориглоно. Зөвшөөрөлгүй хийсэн банк хоорондын төлбөрийн картын гүйлгээнээс гарах аливаа эрсдэлийг карт хүлээн авагч хариуцна.
- 10.3 Свитч нь үр дүнгийн тооцоог өдөрт нэг буюу түүнээс дээш удаа оролцогч талын Монголбанк дахь харилцах дансаар гүйцэтгэнэ.
- 10.4 Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээний төлбөр тооцоог хийгдэж буй гүйлгээний дүнгээс үл хамааран “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний журам”-д заасны дагуу гүйцэтгэнэ.

#### АРВАН НЭГ. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ТӨЛБӨР ТООЦОО, ҮР ДҮНГИЙН ТООЦООЛОЛ

- 11.1 Оролцогч талууд нь бодит цагийн горимоор 24 цагийн хуваариар (24/7) санхүүгийн болон санхүүгийн бус төлбөр тооцоог зөвхөн төгрөгөөр илэрхийлж дамжуулж, хүлээн авна.
- 11.2 Карт гаргагч, хүлээн авагч банкны өдрийн эцсийн үр дүнгийн тооцоолол нь Монголбанкин дахь тухайн банкны харилцах дансаар харилцан суутгах зарчмаар, төгрөгөөр гүйцэтгэгдэнэ.
- 11.3 Карт хүлээн авагч банк нь залруулгын гүйлгээ хийгдэхтэй холбоотой баримтын бүрдлийг хариуцна.
- 11.4 Карт хүлээн авагч банк нь буруу гүйлгээ залруулснаас үүсэх эрсдэлийг бүрэн хариуцна.
- 11.5 ТТГ нь дараах тохиолдолд карт хүлээн авагч банкнаас ирүүлсэн залруулгын хүсэлтийг үндэслэн гүйлгээний мэдээллийг хянаж, зөвшөөрөл олгоно. Уг гүйлгээ нь зөвшөөрөл олгосон өдрийн үр дүнгийн тооцоололд тооцогдоно. Үүнд:
1. Дебет залруулгын хүсэлт буюу карт гаргагч банк зөвшөөрсөн үед;
  2. Кредит залруулгын хүсэлт буюу карт хүлээн авагч банкнаас ирүүлсэн үед.

- 11.6 Залруулгын гүйлгээг дараах нөхцөлд карт хүлээн авагч банк нь ТТТ-ийн веб хуудсанд бүртгэнэ.
1. Үр дүнгийн тооцоололд зөрүү гарч залруулгын гүйлгээ хийх шаардлагатай үед;
  2. Хамтран ажиллах гэрээнд заасан маргаан шийдвэрлэх зарчмын дагуу маргаантай гүйлгээ хаагдаж буй үед.

## АРВАН ХОЁР. ҮНДЭСНИЙ БРЭНД ТӨЛБӨРИЙН КАРТ

- 12.1 Үндэсний картын оноосон нэрийг “Т карт” буюу “Төгрөг карт” гэнэ.
- 12.2 Карт гаргагч банк нь “Банк хоорондын нэгдсэн сүлжээ” (*цаашид* “Нэгдсэн сүлжээ” гэх)-гээр болон өөрийн банкны сүлжээгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын “Т карт”, олон улсад олон улсын “Т card”-аар төлбөр тооцооны үйл ажиллагааг эрхэлж болно.
- 12.3 Үндэсний картын загвар буюу картын хэмжээ, нүүрэн болон ар тал дээр байх мэдээлэл зэргийг энэ журмын 15 дугаар хавсралтад заасан стандартаар мөрдлөг болгон ажиллана.
- 12.4 Карт гаргагчийн таних дугаар (БИН)-ыг карт гаргагч банкинд MNS ISO/IEC 7812-1, MNS ISO/IEC 7812-2 болон ISO3166 стандартын дагуу энэ журмын 16 дугаар хавсралтад зааснаар олгоно.
- 12.5 Үндэсний картын лого, түүний байршлыг 17 дугаар хавсралтад зааснаар байрлуулна.
- 12.6 Үндэсний картын холограмын загвар, түүний байршлыг 18 дугаар хавсралтад зааснаар байрлуулна.
- 12.7 Үндэсний картан дээр байрших ТТТ-ийн лого, түүний байршлыг энэ журмын 19 дүгээр хавсралтад зааснаар байрлуулна.
- 12.8 Үндэсний картын гүйлгээний цахим мэдээг Олон улсын санхүүгийн мэдээний ISO8583 стандартын дагуу энэ журмын 20 дугаар хавсралтад зааснаар үүсгэнэ.
- 12.9 Карт гаргагч банк нь үндэсний картан дээрх загварыг сонгож гаргана.
- 12.10 Монголбанк Үндэсний картын үйл ажиллагаанд мөрдөх шаардлага, үйл ажиллагааны заавар, журмыг батална.
- 12.11 Монголбанк Үндэсний картын үйлчилгээний хүү, шимтгэлийн хэмжээ, хязгаарыг тогтооно.
- 12.12 “Ирээдүй” хүүхдийн ₮ картын дизайн, зургийг энэ журмын 22 дугаар хавсралтад зааснаар гаргана.  
*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А-6 дугаар тушаалаар нэмсэн/](#)*
- 12.13 “Ирээдүй” хүүхдийн ₮ картад Монголбанкнаас олгосон карт гаргагчийн таних дугаар (БИН)-ыг ашиглана.  
*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А-6 дугаар тушаалаар нэмсэн/](#)*
- 12.14 Карт гаргагч банк нь олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагатай хамтран “Хосолсон ₮ карт”-ыг гаргаж болно.  
*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-219 дүгээр тушаалаар нэмсэн/](#)*

1. “Хосолсон ₮ карт”-ын логоны байршлыг энэ журмын 23 дугаар хавсралтад зааснаар гаргана.

*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-219 дүгээр тушаалаар нэмсэн/](#)*

2. “Хосолсон ₮ карт”-д олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагаас олгосон БИН дугаарыг ашиглана.

*[/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-219 дүгээр тушаалаар нэмсэн/](#)*

## АРВАН ГУРАВ. ТӨЛБӨРИЙН КАРТЫН СИСТЕМИЙН ТАСРАЛТГҮЙ, НАЙДВАРТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 13.1 Төлбөрийн картын тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангах, түүнтэй холбогдон гарсан аливаа саатал, гэмтлийг шийдвэрлэхэд оролцогч талууд нь Монголбанкнаас гаргасан журам, зааврыг мөрдлөг болгон ажиллана.
- 13.2 Оролцогч талууд нь төлбөрийн картын тасралтгүй, найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллана.
- 13.3 Оролцогч талууд нь нэгдсэн сүлжээ, өөрийн банкны сүлжээний тасралтгүй, найдвартай ажиллагаанд тавигдах шаардлагуудыг тодорхойлох, түүнтэй холбоотой үүссэн системийн саатлыг шийдвэрлэнэ.
- 13.4 Оролцогч тал нь гэнэтийн саатлаас урьдчилан сэргийлж, төлбөрийн картын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах үүднээс тоног төхөөрөмж, техник, програм хангамжийг эрсдэлийн зэрэглэлээр ялган ангилна.
- 13.5 Оролцогч талууд тус бүрийн системийн урьдчилан төлөвлөгдөөгүй гэнэтийн саатал сард 99.5%-иас доош үзүүлэлттэй гарсан үед Монголбанкны Улсын байцаагч (“Монголбанкны Улсын байцаагчийн дүрэм”, “Банкны тухай хууль”) өөрийн бүрэн эрхийн дагуу асуудлыг шийдвэрлэнэ.
- 13.6 Оролцогч тал нь нөөц сүлжээ, түүний найдвартай ажиллагаа, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хагас жилд нэг удаа туршин баталгаажуулж байна.

## АРВАН ДӨРӨВ. КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 14.1 Тасралтгүй ажиллагаа, системийн аюулгүй байдлыг хангах үүргийг оролцогч талууд хүлээнэ.
- 14.2 Оролцогч тал нь системийн тасралтгүй ажиллагаа, системийн аюулгүй байдлын талаарх баримтлах бодлого, техникийн стандартыг боловсруулсан байна.
- 14.3 Свитч нь тасралтгүй ажиллагаа, системийн аюулгүй байдлыг хангаагүй оролцогчид арга хэмжээ авч болно. Авах арга хэмжээний тухай бүрэн мэдээллийг сүлжээний дүрэмд заасан байна.
- 14.4 Оролцогч талууд төлбөрийн үнэн зөв байдал, тоо баримт ба өгөгдлийн баталгаатай байдлыг бүрэн хариуцна.
- 14.5 Төлбөрийн карт гаргагч байгууллагын төлбөрийн картын боловсруулалт болон хүлээн авагч байгууллагын төлбөрийн картын гүйлгээний боловсруулалт хийхэд ашиглаж байгаа дүрэм,

- журам, гэрээ, програм хангамж, нууцлалын түвшин, боловсон хүчний мэдлэгийн түвшинд Монголбанк шалгалт хийнэ.
- 14.6 Дээр дурдсан шалгалтын үр дүнг Монголбанк шаардлагатай гэж үзвэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.
- 14.7 Төлбөрийн картын гүйлгээний төлбөр тооцоонд оролцогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд харилцагч нь төлбөр тооцоо, үйлчилгээний талаарх санал, хүсэлт, гомдлын асуудлаар Монголбанкинд хандаж болно.
- 14.8 Талууд гэрээгээр харилцан хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гэрээгээ зөрчсөн тохиолдолд Монголбанкны улсын байцаагч зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 14.9 Картын үйл ажиллагаанд оролцогч талууд картын үйл ажиллагааны тайланг хагас жил тутамд гаргаж, дараа сарын 25-ны өдрийн дотор Монголбанкны ТТБГ-т дараахь байдлаар ирүүлнэ:
1. Карт хүлээн авагч нь төлбөрийн картын гүйлгээний тайланг 4 дүгээр хавсралтын дагуу системээр, 5 дугаар хавсралтын дагуу аймгаар тус тус гаргана.
  2. Карт гаргагч нь төлбөрийн картын гүйлгээний тайланг 6 дугаар хавсралтын дагуу системээр, 7 дугаар хавсралтын дагуу аймгаар, эргэлтэд байгаа төлбөрийн картын тайланг 8 дугаар хавсралтын дагуу системээр, 9 дүгээр хавсралтын дагуу аймгаар тус тус гаргана.
  3. Карт гаргагч болон хүлээн авагч банк нь үйлчилгээний төхөөрөмжийн тоо хэмжээний тайланг 10 дугаар хавсралтын дагуу, карт ашиглан хийгдсэн залилангийн гүйлгээний тайланг 11 дүгээр хавсралтын дагуу, бэлэн бус төлбөр тооцооны бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх тайланг 12 дугаар хавсралтын тус тус гаргана.
  4. Свитч нь төлбөрийн картын банк хоорондын гүйлгээний тайланг 13 дугаар хавсралтын дагуу карт гаргагчаар, 14 дүгээр хавсралтын дагуу карт хүлээн авагчаар гаргана.
- 14.10 Энэ журмын 14.9 дэх заалтад заасан тайлан мэдээг Монголбанк нэгтгэж банкны системийн хэмжээний тайланг оролцогч талууд болон олон нийтэд дараа сарын 25-ны өдрийн дотор мэдээлнэ.

#### АРВАН ТАВ. ТӨЛБӨРИЙН КАРТААР ХИЙГДСЭН ГҮЙЛГЭЭНИЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 15.1 Банк хооронд төлбөрийн картаар хийгдсэн карт гаргагч эсхүл хүлээн авагч банкны картаар үйлчлэгч байгууллага (*цаашид* “КҮБ” гэх) болон салбар банкин дээр хийгдсэн гүйлгээтэй холбоотой үүссэн аливаа гомдол, маргааныг оролцогч талууд хамтран шийдвэрлэнэ.
- 15.2 Карт эзэмшигч болон КҮБ нь карт гаргагч эсхүл карт хүлээн авагч банкинд гомдол, маргаан үүсгэхдээ бичгээр хандана. Гомдол, маргаан үүсгэж болох хугацаа, шалтгааны дугаар, маргаантай гүйлгээний талаарх болон холбогдох бусад заалтыг оролцогч талтай байгуулах “Хамтран ажиллах гэрээ”-нд заасны дагуу оролцогч талууд мөрдлөг болгон ажиллана.
- 15.3 Гомдол, маргааны шалтгааны дугаар, тайлбар, шийдвэрлэх хугацааг энэ журмын 20 дугаар хавсралтад зааснаар мөрдөнө.
- 15.4 Монголбанк нь үүссэн маргааныг шийдвэрлэх үүднээс Монголбанкин дахь харилцах данснаас маргааны мөнгөн дүнгийн хэмжээгээр тусгаарлах актив, пассив хосолсон түр данс нээнэ.

- 15.5 Монголбанк оролцогч талын гаргасан гомдол, маргаан аль нэг талын нотолгоогоор бүрэн гүйцэд шийдвэрлэгдсэн тохиолдолд маргаантай мөнгөн дүнг оролцогч талын харилцах дансанд тусгана.

#### АРВАН ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 16.1 Энэ журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Монголбанкнаас дараахь арга хэмжээг авна.
1. Картын төлбөр тооцооны үйл ажиллагааг холбогдох журам, гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй бол холбогдох этгээдэд Төв банк (Монголбанк)-ны тухай, Банкны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
  2. Энэхүү журмыг хэрэгжүүлэх талаар Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтныг Банкны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, холбогдох хууль тогтоомжийн дагуу торгох хүртэл арга хэмжээ авна.
- 16.2 Карт эзэмшигч ПИН кодоо нууцалж чадаагүйн улмаас энэ журмын 4.4.10-д заасан мэдэгдлийг хийхээс өмнө гарсан залилангийн гүйлгээний хохирлыг өөрөө хариуцна.
- 16.3 Карт эзэмшигчийн гарын үсгийг шалгаагүйн улмаас гарсан залилангийн гүйлгээний хохирлыг КҮБ хариуцна.
- 16.4 Карт эзэмшигч бусдад санаатай хохирол учруулахаар завдсанаас бусад тохиолдолд энэ журмын 4.4.10-д заасан мэдэгдлийг хийснээс хойш учирсан хохирлыг карт гаргагч хариуцна.

ЖУРАМД АШИГЛАСАН НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

#	Нэр томьёо (монгол хэлээр)	Нэр томьёо (англи хэлээр)
1	Зайн карт	Contactless card
2	Карт	Payment card
3	Карт гаргагчийг таних дугаар буюу БИН	Bank Identification Number
4	Картын гүйлгээ	Payment card transaction
5	Автомат теллер машин буюу АТМ	Automatic Teller Machine
6	Бэлэн мөнгөний орлогын машин буюу БМОМ	Cash Deposit Machine
7	Хувийн таних дугаар буюу ПИН	Personal Identification Number
8	Санхүүгийн гүйлгээ	Financial transaction
9	Санхүүгийн бус гүйлгээ	Non Financial transaction
10	ПОБ	Point of Banking
11	ПОС	Point of Sale
12	Карт гаргагч	Issuer
13	Карт хүлээн авагч	Acquirer
14	Шууд оролцогч гишүүн	Direct Participant
15	Шууд бус оролцогч гишүүн	Non direct Participant
16	Гүйлгээний зөвшөөрөл	Authorization
17	КУБ	Merchant
18	КУБ-ийн шимтгэл	Merchant Discount Fee
19	Сүлжээний дүрэм	Network Operational Rules
20	Свитчийн шимтгэл	Interchange fee
21	Уламжлалт карт	Contact card

ТӨЛБӨРИЙН КАРТ ГАРГАХ/ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Зорилгоор:

Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй   
\_\_\_\_\_ / оноосон нэр /

өөрийн нэрээр   
олон улсын нэрээр   
\_\_\_\_\_ /төлбөрийн картын оноосон нэр/

Төлбөрийн карт гаргах   
Төлбөрийн карт хүлээн авах

Үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг хүсч байна.

Төлбөрийн карт гаргах/хүлээн авах/свитчийн үйл ажиллагаа эрхлэн явуулснаар банкны тухай болон бусад хууль тогтоомж, эдгээрт нийцүүлэн Монголбанкнаас баталсан эрх зүйн баримт бичгийн холбогдох заалт, шаардлагыг чанд биелүүлэх үүрэг хариуцлага ноогдож байгааг ухамсарлан ойлгосон бөгөөд эдгээрийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллах болно.

Өргөдөлд хавсаргасан баримт бичгийн жагсаалт:

1. Техник тоног төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл. Үүнд:
  - а. Ашиглагдах техник тоног төхөөрөмжийн жагсаалт, зориулалт, тэдгээрийн үйлдвэрлэгчдийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл
  - б. Техникийн баримт бичиг
  - в. Ашигласан технологийн тайлбар
  - г. Тасралтгүй ажиллагааг хангасан байдал
  - д. Нууцлал, аюулгүй байдал хангасан байдал
2. Програм хангамжийн тухай мэдээлэл
  - а. Ашиглагдах програм хангамжийн жагсаалт, зориулалт, тэдгээрийн үйлдвэрлэгчдийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл
  - б. Техникийн баримт бичиг
  - в. Ашигласан технологийн тайлбар
  - г. Тасралтгүй ажиллагааг хангасан байдал
  - д. Нууцлал, аюулгүй байдал хангасан байдал

3. Эрсдэлийн удирдлага, хяналтын тухай мэдээлэл
  - a. Эрсдэлийн үнэлгээ, тэдгээрийн буруулах талаар авах арга хэмжээний жагсаалт
  - b. Тасралтгүй ажиллагааг хангах төлөвлөгөө, онцгой үед авах арга хэмжээний төлөвлөгөө
  - c. Үйл ажиллагааны хяналт хийхэд ашиглагдах заавар, журам
4. Үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах эрх зүйн баримт бичиг /журам, заавар, бусад/
5. Төлбөрийн карт болон төлбөрийн карт эзэмшигчидтэй ажиллах боловсон хүчний дэлгэрэнгүй анкет
6. Энэхүү журмыг мөрдөн ажиллахыг хүлээн зөвшөөрснийг нотлох ТУЗ-ийн тогтоол.

Бүгд . . . . . хуудас

Дээр дурьдсан баримт бичгийг Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан "Төлбөрийн картын тухай журам" - ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлж, хүргүүлж байна. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно. Өргөдөл, материалыг хүлээн авч, хянан шийдвэрлэж төлбөрийн карт гаргах /хүлээн авах/свитчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгож өгнө үү.

Төлбөрийн карт гаргах үйл ажиллагааг эрхэлж эхэлснээс хойш банкны тухай болон бусад хууль тогтоомж, Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/ нэр /

/ тамга /

## СВИТЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Зорилгоор:

Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй



\_\_\_\_\_ /оноосон нэр/

..... банкуудын хооронд

\_\_\_\_\_ /төлбөрийн картын оноосон нэр/ төлбөрийн картын

Свитчийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг хүсч байна.

Свитчийн үйл ажиллагаа эрхлэн явуулснаар банкны тухай болон бусад хууль тогтоомж, эдгээрт нийцүүлэн Монголбанкнаас баталсан эрх зүйн баримт бичгийн холбогдох заалт, шаардлагыг чанд биелүүлэх үүрэг хариуцлага ноогдож байгааг ухамсарлан ойлгосон бөгөөд эдгээрийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллах болно.

Өргөдөлд хавсаргасан баримт бичгийн жагсаалт:

1. Техник тоног төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл. Үүнд:
  - а. Ашиглагдах техник тоног төхөөрөмжийн жагсаалт, зориулалт, тэдгээрийн үйлдвэрлэгчдийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл
  - б. Техникийн баримт бичиг
  - в. Ашигласан технологийн тайлбар
  - г. Тасралтгүй ажиллагааг хангасан байдал
  - д. Нууцлал, аюулгүй байдал хангасан байдал
2. Програм хангамжийн тухай мэдээлэл
  - а. Ашиглагдах програм хангамжийн жагсаалт, зориулалт, тэдгээрийн үйлдвэрлэгчдийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл
  - б. Техникийн баримт бичиг
  - в. Ашигласан технологийн тайлбар
  - г. Тасралтгүй ажиллагааг хангасан байдал
  - д. Нууцлал, аюулгүй байдал хангасан байдал
3. Эрсдэлийн удирдлага, хяналтын тухай мэдээлэл
  - а. Эрсдэлийн үнэлгээ, тэдгээрийн буруулах талаар авах арга хэмжээний жагсаалт

- b. Тасралтгүй ажиллагааг хангах төлөвлөгөө, онцгой үед авах арга хэмжээний төлөвлөгөө
  - c. Үйл ажиллагааны хяналт хийхэд ашиглагдах заавар, журам
4. Үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах эрх зүйн баримт бичиг /журам, заавар, бусад/
  5. Төлбөрийн карт болон төлбөрийн карт эзэмшигчидтэй ажиллах боловсон хүчний дэлгэрэнгүй анкет
  6. Энэхүү журмыг мөрдөн ажиллахыг хүлээн зөвшөөрснийг нотлох ТУЗ-ийн тогтоол.

Бүгд . . . . . хуудас

Дээр дурьдсан баримт бичгийг Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан "Төлбөрийн картын тухай журам" - ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлж, хүргүүлж байна. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно. Өргөдөл, материалыг хүлээн авч, хянан шийдвэрлэж төлбөрийн карт хүлээн авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгож өгнө үү.

Свитчийн үйл ажиллагааг эрхэлж эхэлснээс хойш банкны тухай болон бусад хууль тогтоомж, Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/ нэр /

/ тамга /

“Төлбөрийн картын журам”-ын  
4 дүгээр хавсралт

Төлбөрийн карт хүлээн авагч

**ТӨЛБӨРИЙН КАРТЫН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(СИСТЕМЭЭР)**

(Банкны нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Системийн нэр <sup>1</sup>	Гүйлгээний төрөл <sup>2</sup>	Бэлэн төлбөр								Бэлэн бус төлбөр												
		АТМ-р хийсэн гүйлгээ		БМОМ-р <sup>4</sup> хийсэн гүйлгээ		ПОБ-р хийсэн гүйлгээ		ПОС-р хийсэн гүйлгээ		АТМ-р хийсэн гүйлгээ		БМОМ-р <sup>4</sup> хийсэн гүйлгээ		ПОБ-р хийсэн гүйлгээ		ПОС-р хийсэн гүйлгээ		Интернэтээр хийсэн гүйлгээ		Бусад <sup>3</sup>		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
	I																					
	II																					
	III																					
	IV																					
	V																					
НИЙТ																						

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup> VISA, MasterCard г.м.

<sup>2</sup> Дараахь утгатай байна:

I - банк өөрийн гаргасан картыг ашиглан банкны өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ;

II - банк өөрийн гаргасан картыг ашиглан Монгол Улсын өөр банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ;

III - банк өөрийн гаргасан картыг ашиглан гадаад улсын банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ;

IV - банк өөрийн гаргасан картаас бусад Монголын харьяа байгууллагын гаргасан картыг ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ;

V - Гадаадын байгууллага эсвэл Монгол Улсын бусад банкуудаар дамжуулан гаргасан гадаадын картыг ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ;

<sup>3</sup> Тайлбарыг задаргаатай хавсаргах.

<sup>4</sup> АТМ төхөөрөмжөөр хийгдэх орлогын гүйлгээг БМОМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээнд оруулах.

**ТӨЛБӨРИЙН КАРТЫН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(АЙМГААР)**

(Банкны нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Аймгийн нэр	Гүйлгээний төрөл <sup>1</sup>	Бэлэн төлбөр								Бэлэн бус төлбөр														
		АТМ-р хийсэн гүйлгээ		БМОМ-р <sup>3</sup> хийсэн гүйлгээ		ПОБ-р хийсэн гүйлгээ		ПОС-р хийсэн гүйлгээ		АТМ-р хийсэн гүйлгээ		БМОМ-р <sup>3</sup> хийсэн гүйлгээ		ПОБ-р хийсэн гүйлгээ		ПОС-р хийсэн гүйлгээ		Интернэтээр хийсэн гүйлгээ		Бусад <sup>2</sup>				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
	I																							
	II																							
	III																							
	IV																							
	V																							
НИЙТ																								

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup>Дараахь утгатай байна:

- I - банк өөрийн гаргасан картыг ашиглан банкны өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ;
- II - банк өөрийн гаргасан картыг ашиглан Монгол Улсын өөр банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ;
- III - банк өөрийн гаргасан картыг ашиглан гадаад улсын банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ;
- IV - банк өөрийн гаргасан картаас бусад Монголын харьяа байгууллагын гаргасан картыг ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ;
- V - Гадаадын байгууллага эсвэл Монгол Улсын бусад банкуудаар дамжуулан гаргасан гадаадын картыг ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ;

<sup>2</sup> Тайлбарыг задаргаатай хавсаргах.

<sup>3</sup> АТМ төхөөрөмжөөр хийгдэх орлогын гүйлгээг БМОМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээнд оруулах.

Төлбөрийн карт гаргагч

**ТӨЛБӨРИЙН КАРТЫН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(СИСТЕМЭЭР)**

(Банкны нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Системийн нэр <sup>1</sup>	Гүйлгээний төрөл <sup>2</sup>	Дебет карт		Кредит карт		Урьдчилан төлбөрт карт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	I						
	II						
	III						
	IV						
	V						
НИЙТ							

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup> VISA, MasterCard г.м.

<sup>2</sup> Дараахь утгатай байна:

I - банк өөрийн гаргасан картыг ашиглан банкны өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ

II - банк өөрийн гаргасан картыг ашиглан Монгол Улсын өөр банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ

III - банк өөрийн гаргасан картыг ашиглан гадаад улсын банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ

IV - банк өөрийн гаргасан картаас бусад Монголын харьяа байгууллагын гаргасан картыг ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ

V - Гадаадын байгууллага эсвэл Монгол Улсын бусад банкуудаар дамжуулан гаргасан гадаадын картыг ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ

**ТӨЛБӨРИЙН КАРТЫН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(АЙМГААР)**

(Банкны нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Аймгийн нэр	Гүйлгээний төрөл <sup>1</sup>	Дебет карт		Кредит карт		Урьдчилан төлбөрт карт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Архангай	I						
	II						
	III						
	IV						
	V						
....							
Улаанбаатар хот	I						
	II						
	III						
	IV						
	V						
НИЙТ							

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup> Дараахь утгатай байна:

I - банк өөрийн гаргасан картыг ашиглан банкны өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ

II - банк өөрийн гаргасан картыг ашиглан Монгол Улсын өөр банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ

III - банк өөрийн гаргасан картыг ашиглан гадаад улсын банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ

IV - банк өөрийн гаргасан картаас бусад Монголын харьяа байгууллагын гаргасан картыг

ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ

V - Гадаадын байгууллага эсвэл Монгол Улсын бусад банкуудаар дамжуулан гаргасан гадаадын картыг ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ

“Төлбөрийн картын журам”-ын  
8 дугаар хавсралт

Төлбөрийн карт гаргагч

**ЭРГЭЛТЭНД БАЙГАА ТӨЛБӨРИЙН КАРТЫН ТАЙЛАН  
(СИСТЕМЭЭР)**

(Банкны нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Системийн нэр <sup>1</sup>	Картын төрөл <sup>2</sup>	Картын валютын төрөл	Карт эзэмшигчийн нийт тоо	Олгосон картын нийт тоо	Тайлант хугацаанд ашиглагдсан картын тоо
	I	MNT			
	I	USD			
	...	...	...	...	...
	II	MNT			
	II	USD			
	...	...	...	...	...
	III	MNT			
	III	USD			
...	...	...	...	...	...
НИЙТ					

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup> VISA, MasterCard г.м.

<sup>2</sup> Дараахь утгатай байна:

I - Дебет карт

II – Кредит карт

III– Урьдчилсан төлбөрт карт

**ЭРГЭЛТЭНД БАЙГАА ТӨЛБӨРИЙН КАРТЫН ТАЙЛАН  
(АЙМГААР)**

(Банкны нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Аймгийн нэр	Картын төрөл <sup>1</sup>	Картын валютын төрөл	Эргэлтэнд байгаа картын тоо	Ашиглагдаж байгаа картын тоо <sup>2</sup>	Карт эзэмшигчийн тоо	Карт ашиглагчийн тоо <sup>3</sup>	Сарын дундаж үлдэгдэл
Архангай	I	MNT					
	I	USD					
	...	...	...	...	...		
	II	MNT					
	II	USD					
	...	...	...	...	...		
	III	MNT					
III	USD						
...	...	...	...	...	...		
Улаанбаатар	I	MNT					
	I	USD					
	...	...	...	...	...		
	II	MNT					
	II	USD					
	...	...	...	...	...		
	III	MNT					
III	USD						
НИЙТ	...	...	...	...	...		

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup> Дараахь утгатай байна:

I - Дебет карт

II – Кредит карт

III– Урьдчилсан төлбөрт карт

<sup>2</sup> Сард 5 буюу түүнээс дээш удаа ашиглагдсан картуудыг оруулна.

<sup>3</sup> Сард 5 буюу түүнээс дээш удаа картаа ашигладаг карт эзэмшигчийг оруулна.

“Төлбөрийн картын журам”-ын  
10 дугаар хавсралт

Карт хүлээн авагч

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

\_\_\_\_\_ (Банкны нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Аймгийн нэр	ПОС төхөөрөмжийн тоо		Импринтерийн тоо		АТМ төхөөрөмж ийн тоо	БМОМ төхөөрөм жийн тоо	Бусад <sup>1</sup>	
	Банкинд	Байгууллагад	Банкинд	Байгууллагад			Банкинд	Байгууллагад
Архангай								
Баян-Өлгий								
.....								
Увс								
Улаанбаатар								
НИЙТ								

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup> Тайлбарыг задаргаатай хавсаргах

## КАРТ АШИГЛАН ХИЙГДСЭН ЗАЛИЛАНГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Банкны нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Системийн нэр <sup>1</sup>	Гүйлгээний төрөл <sup>2</sup>	Гүйлгээ хийгдсэн огноо	Залилангийн арга <sup>3</sup>	Гүйлгээ <sup>4</sup>	Гүйлгээ хийгдсэн орчин <sup>5</sup>	Хийгдсэн гүйлгээний дүн (мянган төгрөг)

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup> VISA, MasterCard г.м.

<sup>2</sup> Дараахь утгатай байна:

- I - банк өөрийн гаргасан картыг ашиглан банкны өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ
- II - банк өөрийн гаргасан картыг ашиглан Монгол Улсын өөр банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ
- III - банк өөрийн гаргасан картыг ашиглан гадаад улсын банкны сүлжээгээр хийсэн гүйлгээ
- IV - банк өөрийн гаргасан картаас бусад Монголын харьяа байгууллагын гаргасан картыг ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ
- V - Гадаадын байгууллага эсвэл Монгол Улсын бусад банкуудаар дамжуулан гаргасан гадаадын картыг ашиглан өөрийн сүлжээгээр хийсэн гүйлгээ

<sup>3</sup> Залилангийн арга багананд дараахь мэдээлэл байна:

- 1 - гээгдсэн, алдагдсан картууд
- 2 - карт гаргах, илгээх үед карт эзэмшигч хүлээж аваагүй картууд
- 3 - хуурамчаар хийгдсэн картууд
- 4 - давхар уншуулах
- 5 - шуудан, утас, интернетээр захиалсан
- 6 - бусад (төлбөрийн карт эзэмшигч дансаа урвуулан ашиглах, төлбөрийн картыг хулгайд алдсан, гэж үрэгдүүлсэн талаар худал өргөдөл гаргах г.м)
- 7-бусад (тайлбарыг хавсрагана)

<sup>4</sup> Гүйлгээ багананд дараахь мэдээлэл байна:

- A - бэлэн бус төлбөр тооцоо
- B - бэлэн мөнгө гаргах ажиллагаа

<sup>5</sup> Гүйлгээний орчин багананд дараахь мэдээлэл байна:

- A - АТМ
- B- БМОМ
- C - ПОС терминал
- D- импринтер
- E – интернет
- F- бусад (Тайлбарыг хавсаргана)

**БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦООНЫ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛАН**

(Банкны нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Бүтээгдэхүүн / үйлчилгээний нэр	Нэвтрүүлсэн огноо	Онцлог/ зориулалт	Заавал байлгах үлдэгдэл	Жилийн хураамж	Гүйлгээний шимтгэл	Урамшуулал (нэгж гүйлгээ)	Гэрээг байгууллагын тоо	Хүү тооцох үлдэгдэл	Сарын хүү	Нэг гүйлгээний хязгаар	Өдрийн гүйлгээний хязгаар

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

**ТӨЛБӨРИЙН КАРТЫН БАНК ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(КАРТ ГАРГАГЧААР)**

(Свитчийн нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Карт гаргагчийн нэр	Бэлэн төлбөр								Бэлэн бус төлбөр												
	АТМ-р хийсэн гүйлгээ		БМOM-р <sup>2</sup> хийсэн гүйлгээ		ПOB-р хийсэн гүйлгээ		ПOC-р хийсэн гүйлгээ		АТМ-р хийсэн гүйлгээ		БМOM-р <sup>2</sup> хийсэн гүйлгээ		ПOB-р хийсэн гүйлгээ		ПOC-р хийсэн гүйлгээ		Интернэтээр хийсэн гүйлгээ		Бусад <sup>1</sup>		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
НИЙТ																					

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup> Тайлбарыг задаргаатай хавсаргах.

<sup>2</sup> АТМ төхөөрөмжөөр хийгдэх орлогын гүйлгээг БМOM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээнд оруулах.

**ТӨЛБӨРИЙН КАРТЫН БАНК ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
**(КАРТ ХҮЛЭЭН АВАГЧААР)**

(Свитчийн нэр)

20\_\_ оны эхний (эцсийн) хагас жилийн байдлаар

Карт хүлээн авагчийн нэр	Бэлэн төлбөр								Бэлэн бус төлбөр												
	АТМ-р хийсэн гүйлгээ		БМOM-р <sup>2</sup> хийсэн гүйлгээ		ПОб-р хийсэн гүйлгээ		Пос-р хийсэн гүйлгээ		АТМ-р хийсэн гүйлгээ		БМOM-р <sup>2</sup> хийсэн гүйлгээ		ПОб-р хийсэн гүйлгээ		Пос-р хийсэн гүйлгээ		Интернэтээр хийсэн гүйлгээ		Бусад <sup>1</sup>		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>НИЙТ</b>																					

КАРТЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ \_\_\_\_\_

(Овог Нэр)

\_\_\_\_\_  
(Утасны дугаар)

20\_\_ оны \_\_ сарын \_\_ - ны өдөр

<sup>1</sup> Тайлбарыг задаргаатай хавсаргах.

<sup>2</sup> АТМ төхөөрөмжөөр хийгдэх орлогын гүйлгээг БМOM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээнд оруулах.

## ҮНДЭСНИЙ КАРТЫН ЗАГВАР

- 1.1 Үндэсний картын хэмжээ нь тэгш өнцөгт хэлбэртэй ба дараах хэмжээтэй байна.
1. Өргөн:  $W=85.60 \text{ мм} \pm 0.30 \text{ мм}$
  2. Өндөр:  $H=53.98 \text{ мм} \pm 0.30 \text{ мм}$
  3. Зузаан:  $T=0.76 \text{ мм} \pm 0.08 \text{ мм}$
  4. Булангийн тойрог:  $3.18 \pm 0.30 \text{ мм}$
- 1.2 Үндэсний картын нүүрэн талд дараах мэдээллүүдийг агуулсан байна.
1. Карт гаргагч банкны нэр, лого эсхүл ко-брэнд байгууллагын нэр
  2. Картын дугаар (16 оронтой: эхний 6 орон карт гаргагчийг таних дугаар, дараагийн дугаар нь үндэсний карт эзэмшигчийн дансны дугаар, сүүлийн 1 орон нь хяналтын дугаар байна. Хавсралт 16)
  3. Үндэсний картын лого (Хавсралт 17)
  4. Үндэсний картын холограм (Хавсралт 18)
  5. Чип (хэрэв үндэсний картын чиптэй бол ISO/IEC 7816-1/2/3 стандартын шаардлагын дагуу контакт чип, зайнаас унших чип эсхүл хослуулсан байж болно. Чипийг зөвхөн картын нүүрэн талын зүүн хэсэгт картын дугаар дээр байрлана. (Хүснэгт 1)
  6. Картын хүчинтэй хугацаа (эхлэх болон дуусгавар болох хугацаа, хүчинтэй хугацаа нь хэвлэгдээгүй картын хувьд дуусах хугацаагүй гэж ойлгоно.)
- 1.3 Монголбанкнаас баталсан үндэсний картын загварын шаардлагыг хангаж дараах мэдээллийг гурван шугаманд бичнэ. Үндэсний картын гадаргуун дээрх тэмдэгтийг товойлгон бичих болон лазераар хэвлэх зэрэг хэвлэлийн технологийг ашиглаж болно.
1. Картын дугаар (Хүснэгт 2)
  2. Карт эзэмшигчийн овгийн эхний үсэг болон нэрийн үсгүүд том үсгээр, латин галигаар бичигдэнэ. (Хүснэгт 3)
  3. Картын хүчинтэй хугацаа нь сар, жил гэсэн дараалалтай, тус тус 00 гэсэн 2 оронтой аравтын тооллын тоо байна. (Хүснэгт 4) Картан дээрх хугацаа нь соронзон тууз эсхүл чипний мэдээлэлтэй ижил байдаг.

### Хүснэгт 1. Чипний стандарт байрлал, хэмжээ

№	Тайлбар	Байрлал, хэмжээ
1	Контакт чип	Картын зүүн хэсэгт картын дугаарын дээр, ISO7816 стандартын дагуу байрлана.
2	Өндөр	9.32 мм
3	Өргөн	9.62 мм
4	A. Чипний дээд булангаас картын дээд ирмэг хүртэл	19.23 мм
5	B. Чипний зүүн булангаас картын зүүн ирмэг хүртэл	10.25 мм
6	C. Чипний доод булангаас картын дээд ирмэг хүртэл	28.55 мм
7	D. Чипний баруун булангаас картын зүүн ирмэг хүртэл	19.87 мм

### Хүснэгт 2. Үндэсний картын дугаар бичих стандарт

№	Тайлбар	Үзүүлэлт
1	Картын дугаарын тэмдэгтийн хэвтээ төвийн шугамаас картын доод ирмэг хүртэл	21.42 мм $\pm$ 0.12 мм
2	Картын дугаарын эхний тэмдэгтийн хэвтээ төвийн шугамаас картын зүүн ирмэг хүртэл	10.18 мм $\pm$ 0.25 мм
3	Картын дугаарын сүүлийн тэмдэгтийн хэвтээ төвийн шугамаас картын зүүн ирмэг хүртэл	75.50 мм $\pm$ 0.76 мм
4	Картын дугаарын товойлгосон тэмдэгтүүдийн доод ирмэгээс БИН дугаарын эхний 4 тэмдэгт хүртэл	1.19 мм $\pm$ 0.10 мм

5	Товойлгон бичсэн картын дугаарын фонт	Farrington 7B, үүнээс жижиг, 12Pt-с багагүй
6	Товойлгон бичсэн картын дугаарын тэмдэгтийн өндөр	5 мм ±0.10 мм
7	Картын дугаарын зэргэлдээ хоёр тэмдэгтийн босоо төвийн шугам хоорондын зай	3.63 мм ±0.10 мм
8	Товойлгон бичсэн тэмдэгтүүдийн гүдгэрийн өндөр	0.46 мм
9	Эхний тэмдэгтийн босоо төвийн шугам, картын дугаарын сүүлийн тэмдэгтийн хоорондын хамгийн их хуримтлагдсан хэмжээ	±0.08 мм

### Хүснэгт 3. Карт эзэмшигчийн овог, нэр бичих стандарт

№	Тайлбар	Хэвлэлтийн шаардлага
1	Карт эзэмшигчийн нэрийн байрлал	Карт эзэмшигчийг тодотгох хэсэгт 2 дахь мэдээллийн шугаманд товойлгон бичнэ.
2	Карт эзэмшигчийн нэрийг товойлгон бичих тэмдэгтийн фонт.	Letter/number font in OCR-B size I
3	Карт эзэмшигчийн нэрийн хэсэг дэх мэдээллийн шугам бүрийн өндрийн хэмжээ.	4 мм ± 0.10 мм
4	Карт эзэмшигчийн нэр бичсэн тэмдэгтийн хоорондын ердийн зай.	2.54 мм ± 0.10 мм
5	Эхний тэмдэгтийн босоо төвийн шугамаас картын зүүн ирмэг хүртэл.	≥7.65 мм ± 0.30 мм
6	Нэр тодотгох хэсгийн доод булангаас картын доод ирмэг хүртэл.	≥2.54 мм
7	Товойлгон бичсэн тэмдэгтийн гүдгэрийн өндрийн хэмжээ.	0.46 мм
8	Мэдээллийн шугам бүрийн эхний тэмдэгт болон сүүлийн тэмдэгтийн босоо төвийн шугамын хооронд хуримтлагдсан хамгийн дээд хэмжээ.	±0.08 мм

### Хүснэгт 4. Картын хүчинтэй хугацаа бичих стандарт

№	Хэсэг	Үзүүлэлтүүд болон хэвлэлтийн шаардлагууд
1	Дуусах хугацааг товойлгон бичих байрлал	Карт эзэмшигчийн мэдээллийг эхний мөрт товойлгон бичнэ
2	Дуусах хугацааны тайлбар	1. Дуусах хугацааны гэсэн тэмдэглэгээний зүүн талд нь хэвлэх 2. Картын үндсэн өнгөнөөс ялгарахаар хэвлэх 3. Некvetica type фонтоор 4-6 хэмжээтэй
3	Бусад мэдээллийг товойлгон бичих байрлал	Карт эзэмшигчийн мэдээллийн хэсгийн 2, 3 дугаар мөрт товойлгон бичих
4	Дуусах хугацааны фонт, тэмдэгтүүдийн өндөр	OCR-B фонтоор 1 хэмжээтэй тэмдэгтүүд
5	Дуусах хугацаанд зориулсан мэдээллийн шугамны өндрийн дээд хэмжээ	4 мм ±0.10 мм
6	Дуусах хугацааны тэмдэгтүүдийн хоорондын ердийн зай	2.54 мм ±0.10 мм
7	Дуусах хугацааны эхний тэмдэгтийн босоо төвийн шугамаас картын зүүн ирмэг хүртэл	≥7.64 мм ±0.10 мм
8	Товойлгон хэвлэсэн тэмдэгтүүдийн гүдгэрийн өндөр	0.46 м

1.4 Үндэсний картын ар тал дараах мэдээллийг агуулсан байна.

1. Соронзон тууз нь ISO 7811 стандартын дагуу мэдээллийг хадгална. Соронзон туузын өгөгдлийн хэмжээ болон техникийн үзүүлэлт (GB/T 19584-2004), ISO/IEC 7811 (2, 4-6)-д заасан шаардлагатай нийцсэн байна.
2. Гарын үсгийн хэсэг нь карт эзэмшигчийн гарын үсэг (зөвхөн гарын үсгийн дагуу үйлчлэх тул картын баруун талд хэвлэнэ. Гарын үсэг зурах наалт нь үндэсний картын нэртэй адил буюу “Т карт” гэсэн үг бүхий байна.)
3. ТТТ-ийн лого нь картын зүүн доод хэсэгт байрлана. (Хавсралт 19)
4. Картыг гаргагч банк нь картыг ашиглах боломжтой төлбөрийн картын бусад сүлжээний логог ТТТ-ийн логоны баруун талын хэсэгт нэмж байрлуулж болно.
5. Карт гаргагч банкны мэдээллийг ТТТ –ийн лого болон нэмэлт сүлжээний логоны баруун талын хэсэгт бичнэ. (Карт гаргагч банкны нэр, эзэмших эсхүл ашиглахыг хориглосон заалт, банкны хаяг, картын талаар мэдээлэл авах утас, факсын дугаар, цахим хуудасны хаяг зэрэг мэдээлэл байж болно)

1.5 Гарын үсгийн хэсэг нь карт эзэмшигч гарын үсэг зурахад зориулагдсан дараах стандартыг хангасан талбай байна.

1. Өргөн A:57.00мм ( $\pm 0.3$ мм)
2. Өндөр B:10.00мм ( $\pm 0.3$ мм)
3. Талбарын баруун ирмэгээс картын баруун ирмэг хүртэл C:25.00мм ( $\pm 0.3$ мм)
4. Талбарын дээд ирмэгээс картын дээд ирмэг хүртэл D:19.50мм ( $\pm 0.3$ мм)

1.6 Карт гаргагч банк нь өөрийн картын бүтээгдэхүүний нэр төрөлд тохирсон загвараар үндэсний карт хэвлэж болно. Бүтээгдэхүүний нэр, картын төрөл болон худалдааны тэмдэгтийг хэвлэхдээ товойлгох аргыг ашиглахгүй. Ямар ч фонтоор хэвлэсэн тэмдэгтийн ердийн зай нь хоорондоо 2.54 мм, мэдээллийн шугамын өндрийн хэмжээ 5 мм-с хэтрэхгүй байна.

## ҮНДЭСНИЙ КАРТ ЭЗЭМШИГЧИЙН КАРТЫН ДУГААР

- 1.1. Үндэсний карт эзэмшигчийн картын дугаар нийт 16 оронтой дараах бүтэцтэй байна.
  1. Үндэсний карт гаргагчийн таних дугаар – нийт 6 оронтой.
  2. Картын дансны дугаар – 9 оронтой
  3. Хяналтын дугаар – 1 оронтой
- 1.2. Үндэсний карт гаргагчийн таних дугаар нь дараах стандарттай байна.
  1. Карт гаргагчийн таних дугаар нь нийт 4 оронтой. Үүнийг Үндэсний стандартын байгууллагаас MNS ISO/IEC 7812-1:2004, MNS ISO/IEC 7812-2:2005 стандартын дагуу салбарын таних дугаар болох 9-оор эхэлж, ISO3166 стандартын дагуу Монгол Улсын код болох 496 дугаартай байна.
  2. Карт гаргагч банкны дугаар 2 оронтой байна. Монголбанк энэ дугаарыг олгоно.
- 1.3. Картын дансны дугаар нийт 9 оронтой байх бөгөөд үндэсний карт эзэмшигчийн картын төрлөөс хамаарч карт гаргагч банк олгоно.
- 1.4. Хяналтын дугаар нь нийт 1 оронтой байна. MNS ISO/IEC 7812-1:2004 стандартад зааснаар Модуло 10 “2 дахин-нэм-2 дахин” Лухнийн томъёогоор тооцно. Үүнд:
  1. Картын дугаарын баруун талын захын цифрээс эхлэн орон алгасан 2-оор үржүүлнэ.
  2. Нэгдүгээрт гарсан тоонуудын оронг бүрдүүлэгч бүрийг болон эхний үед өөрчлөлт ороогүй алгассан оронгуудын хамт нэг бүрчлэн нэмнэ.
  3. Хоёрдугаарт гарсан нийлбэрийг тэр тооны дараагийн 0-ээр төгссөн их тооноос хасна. (Энэ нь нийлбэрийн бага дарааллын тооны аравтын гүйцээгчийн тооцоолсонтой тэнцүү байна. Хэрэв хоёрдугаар тооцооллоос гарсан нийлбэр нь өөрөө 0-ээр төгссөн (30, 40 гэх мэт) тоо бол хяналтын цифр нь 0 болно.)


## ҮНДЭСНИЙ КАРТЫН ЛОГО, ТҮҮНИЙ БАЙРШИЛ

1.1 Үндэсний картын лого дараах өнгөний кодтой байна.


Хүснэгт 1. Логоны өнгөний код

	C	M	Y	K	R	G	B
Логоны цэнхэр	100	60	0	0	102	179	0
Хүрээний өнгө	100	100	0	60	13	0	76

1.2 Логоны үндсэн байгуулалт болон харьцаа дараах бүтэцтэй байна.



1.3 Үндэсний картын логоны байршлын стандарт.




Хүснэгт 2. Логоны байршлын стандарт

№	Тайлбар	Шаардлага
1	Өргөн (тусгал)	12.52 мм
2	Өндөр	17.16 мм
3	Картын баруун ирмэгээс логоны баруун ирмэг хүртэл	3.00 мм
4	Картын доод ирмэгээс логоны доод ирмэг хүртэл	3.00 мм

## ҮНДЭСНИЙ КАРТЫН ХОЛОГРАМЫН ЗАГВАР, ТҮҮНИЙ БАЙРШИЛ

1 Үндэсний картын логотой ижил дүрстэй, 3 үетэй, 3D хэлбэрээр харагдах мөнгөн саарал өнгөтэй.




1.1 Холограммын харьцаа

4a



5.5a

1.2 Үндэсний картын холограммын байршлын стандарт.



Хүснэгт 1. Холограммын байршлын стандарт

№	Тайлбар	Шаардлага
1	Өргөн (тусгал)	12.52 мм
2	Өндөр	17.16 мм
3	Картын баруун ирмэгээс холограммын баруун ирмэг хүртэл	3.00 мм
4	Картын доод ирмэгээс холограммын доод ирмэг хүртэл	3.00 мм
5	Лого болон холограм хоорондын зай	1.96 мм

## ТӨЛБӨР ТООЦООНЫ ТӨВИЙН ЛОГО, ТҮҮНИЙ БАЙРШИЛ

1.1 Төлбөр тооцооны төв (ТТТ)-ийн лого дараах өнгөний кодтой байна.


Хүснэгт 1. Логоны өнгөний код

	C	M	Y	K	R	G	B
Логоны хар хөх өнгө	100	100	10	25	37	33	109
Логоны шар өнгө	0	20	100	0	255	203	5
Логоны цэнхэр өнгө	100	60	0	0	0	102	179
₮ NETC сүүдрийн өнгө	100	100	25	50	22	13	71

1.2 Логоны үндсэн байгуулалт болон харьцаа дараах бүтэцтэй байна.



1.3 ТТТ-ийн логоны байршлын стандарт.



Хүснэгт 2. Логоны байршлын стандарт

№	Тайлбар	Шаардлага
1	Өргөн (тусгал)	13.6 мм
2	Өндөр	10.00 мм
3	Картын зүүн ирмэгээс логоны зүүн ирмэг хүртэл	3.00 мм
4	Картын доод ирмэгээс логоны доод ирмэг хүртэл	3.00 мм

## ҮНДЭСНИЙ КАРТААР ХИЙГДЭХ ГҮЙЛГЭЭНИЙ ЦАХИМ МЭДЭЭНИЙ БҮТЭЦ

- 1.1 Үндэсний картаар банк хооронд болон өөрийн банкны сүлжээнд хийгдэх гүйлгээний цахим мэдээ нь Олон улсын санхүүгийн мэдээний ISO8583 стнадартын дараах бүтэцтэй байна.
- 1.2 ТТТ болон карт гаргагч, хүлээн авагч банкны картын удирдлагын програм хангамжид нийлүүлэгч компаний зүгээс системийн шинэчлэл, өөрчлөлт хийх, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд гүйлгээний цахим мэдээнд өөрчлөлт орох, шинэ талбарууд нэмэгдэхэд талууд харилцан туршилт хийж, баталгаажуулсаны үндсэн дээр нэвтрүүлнэ.
- 1.3 Энэхүү хавсралт нь үндэсний картаар хийгдэх санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээний дэлгэрэнгүй бүтцийг агуулж байгаа бөгөөд бүтцийг задруулахгүй байх үүднээс нууцлалын зэрэглэлтэй байлгах үүргийг оролцогч талууд хүлээнэ.
- 1.4 Оролцогч талуудын хүсэлтээр гүйлгээний цахим мэдээний бүтцэд өөрчлөлт орох бол бол тухай бүрт хавсралтаар шинэчилж байх.

### 1. Үндэсний картаар хийгдэх гүйлгээний жагсаалт

Хүснэгт 1. Төлбөрийн картаар хийгдэх гүйлгээний жагсаалт

№	Төлбөрийн картын гүйлгээний жагсаалт	Гүйлгээний цахим мэдээний төрөл	Хариу гүйлгээний цахим мэдээ	Төхөөрөмж		
				АТМ	ПОС	ПОБ
1	Худалдан авалт – purchase	200	210		√	
2	Бэлэн мөнгө авах – withdrawal	200	210	√		√
3	Үлдэгдэл шалгах - balance inquiry	200	210	√	√	√
4	Худалдан авалтын буцаалт - purchase reversal	400	410		√	
5	Бэлэн мөнгө авалтын буцаалт - withdrawal reversal	400	410	√		√
6	АТМ-ын хэсэгчлэн буцаалт – withdrawal partial dispense	400	410	√		
7	Сүүлийн 10 гүйлгээний жагсаалт – last 10 transaction	200	210	√	√	√
8	Орлого – deposit	200	210	√		√
9	Шилжүүлэг - transfer	200	210	√		√
10	Оролцогч талуудын хүсэлтээр нэмэгдэх бусад төрлийн гүйгээ – other type transaction	200	210	√	√	√

ГОМДОЛ, МАРГААНЫ ШАЛТГААН, ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦАА

№	Код	Маргаан үүсгэж болох тохиолдлууд	Гомдол гаргаж болох хугацаа /хоногоор/	Анхан шатны маргаан буюу гүйлгээний баримт, мэдээлэл хүсэх хугацаа /хоногоор/		Хоёр дахь шатны маргаанаар шийдвэрлэх хугацаа /хоногоор/		
				шийдвэрлэх	нийт	маргаан ирүүлэх	маргааны зөвшөөрөх эс зөвшөөрөх	нийт
<b>А. Мэдээлэл</b>								
1	60	Гүйлгээний баримт харагдахгүй эсхүл гаргацгүй	45	14	59	30	30	119
2	75	Огт танихгүй мэдэхгүй гүйлгээ	120	14	134	30	30	194
<b>Б. Луйвар</b>								
3	57	Луйврын олон цуврал гүйлгээ гарсан тохиолдолд	120	14	134	30	30	194
4	62	Луйврын гүйлгээ	120	14	134	30	30	194
5	81	Карт оролцсон луйврын болон зөвшөөрөлгүй гүйлгээ	120	14	134	30	30	194
6	83	Карт оролцоогүй луйврын болон зөвшөөрөлгүй гүйлгээ. /Мэйл ордер болон интернет/	120	14	134	30	30	194
7	93	КҮБ-ын програм дээр хийгдсэн луйвар	120	14	134	30	30	194
<b>В. Зөвшөөрөл шалгах</b>								
8	70	Карт нөхөн олгох сан болон хаягдсан картын сан.	75	14	89	30	30	149
9	71	Зөвшөөрлийн код цуцлагдсан	75	14	89	30	30	149
10	72	Зөвшөөрлийн код авагдаагүй	75	14	89	30	30	149
11	73	Хугацаа дууссан картын гүйлгээ	75	14	89	30	30	149
12	78	Үйлчилгээний кодын өөрчлөлт	75	14	89	30	30	149
<b>Г.Процессын алдаа</b>								
13	74	Хугацаа хоцруулсан нэхэмжлэл буюу нэгтгэл дүн	90	14	104	30	30	164
14	76	Мөнгөн тэмдэгт болон гүйлгээний код буруу байх эсвэл ханшийн зөрүү гарсан тохиолдолд	90	14	104	30	30	164
15	77	Картын дугаар картын системд байхгүй тохиолдолд	90	14	104	30	30	164
16	80	Үнийн дүн өөрчлөгдөх эсвэл картын дугаар өөрчлөгдөх	90	14	104	30	30	164
17	82	Давхардсан гүйлгээ	90	14	104	30	30	164
18	86	Картнаас өөр хэлбэрээр төлбөрийг төлсөн тохиолдолд	90	14	104	30	30	164
19	96	Өдрийн болон бусад хязгаараас давсан гүйлгээ хийгдсэн үед	90	14	104	30	30	164
<b>Д. Бусад</b>								
20	41	Буцаагдсан гүйлгээг хүчингүй болгосон тохиолдолд	90	14	104	30	30	164

21	53	Үйлчилгээ хангалтгүй эсхүл бараа гэмтэлтэй тохиолдолд	90	14	104	30	30	164
22	85	Картын буцаалт эргэн ороогүй тохиолдолд	90	14	104	30	30	164
23	30	Үйлчилгээ үзүүлээгүй эсхүл бараа хүлээн аваагүй	90	14	104	30	30	164
24	90	АТМ төхөөрөмжөөс мөнгө аваагүй тохиолдолд	30	7	37	30	30	97
25	100	Бусад	90	14	104	30	30	164

"Төлбөрийн картын журам"-ын  
22 дугаар хавсралт  
[/Энэ хавсралтыг Монголбанкны  
Ерөнхийлөгчийн 2013 оны 1 дүгээр сарын  
16-ны өдрийн А-6 дугаар тушаалаар  
нэмсэн/](#)

### "ИРЭЭДҮЙ" ХҮҮХДИЙН ₮ КАРТЫН ЗАГВАР

1. Хүүхдийн ₮ картыг энэхүү журамд заасан Үндэсний картын загвар, түүнд тавигдах стандартын дагуу гаргана.
2. Хүүхдийн ₮ картын нүүрэн тал дараах бүтэцтэй байна.



3. Хүүхдийн ₮ картыг анх хэвлэхдээ картын нүүрэн талын хүүхдийн зургийг карт эзэмшигчийн хүсэлтийн дагуу Хүний хөгжил сангаас мөнгө олгогдож байгаа тухайн хүүхдийн зургаар сольж байршуулж болно.


“ХОСОЛСОН ₮ КАРТ”-ЫН ЛОГОНЫ БАЙРШИЛ

1.1 “Хосолсон ₮ карт” дээр Хүснэгт 1-д заасан лого, холограм байршина:

Хүснэгт 1. Лого, холограмын байршил

№	Лого	Байршил	
		Нүүрэн тал	Ар тал
1	“Хосолсон ₮ карт”-ын лого, холограмын загвар, хэмжээ, өнгө, байршлын стандартыг энэ журмын 17, 18 дугаар хавсралтад зааснаар мөрдөнө.  Энэ хавсралтын 1.2 дахь заалтад зааснаар “Хосолсон ₮ карт”-ын нүүрэн талд үндэсний картын лого, холограмыг картын баруун дээд эсхүл баруун доод хэсэгт байрлуулна.	✓	
2	ҮЦГТ-ийн логоны байршлын стандартыг энэ журмын 19 дүгээр хавсралтад заасны дагуу мөрдөнө.		✓
3	Карт гаргагч банк нь өөрийн дотоод журмын дагуу логоны загвар, түүний байршлын стандартыг баримтлана.	✓	✓
4	Олон улсын картын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагаас гаргасан журмын дагуу олон улсад ашиглагдах логоны загвар, түүний байршлын стандартыг мөрдөнө.	✓	✓

1.2 “Хосолсон ₮ карт”-ын лого, холограмын байрлал (баруун доод, баруун дээд хэсэг).



## ЦАХИМ МЭДЭЭ ҮҮСГЭГЧ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

### 1. Үндсэн шаардлага

- 1.1. Төлбөрийн карт хүлээн авах цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж дээр тухайн карт хүлээн авагч банк болон ҮЦГТ-ийн логог карт эзэмшигчид харагдахуйцаар ил тод байрлуулах.
- 1.2. Цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж нь санхүүгийн гүйлгээний мөнгөн дүнг мөнгөний хоёр оронг “ . ” тэмдгээр, төгрөгийн оронг мянгачлан “ , ” тэмдэг эсвэл зай ашиглан тусгаарлаж харуулах.  
Жишээ нь: xxx,xxx.xx
- 1.3. Цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж дээр ПИН кодыг дараах байдлаар тохируулна:
  - 1.3.1. ПИН код болон шифрлэж нууцалсан ПИН кодыг хадгалдаггүй, ашиглалтын дараа устгадаг байх;
  - 1.3.2. ПИН кодыг дэлгэц дээр нууцалсан хэлбэрээр харуулдаг байх;
  - 1.3.3. Цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж нь ПИН кодыг нууц түлхүүр ашиглан шифрлэж, дамжуулдаг байх.
- 1.4. Цахим мэдээ үүсгэгч төхөөрөмж нь ПИН кодыг програм хангамжид дамжуулахаас өмнө шифрлэж, нууцалдаг тусгай зориулалтын гар (ПИН пад)-тай байх;
  - 1.4.1. ПИН пад нь нууцлал болон боловсруулалтын тусгай хэсгүүдийг агуулсан байх ба ПИН кодын шифрлэлт/шифр гаргалт болон баталгаажуулалтын үйлдлийг дэмждэг байх;
  - 1.4.2. ПИН пад нь 1.4.1-т ашиглагдах хэд хэдэн төрлийн түлхүүрийг уншигдахаас хамгаалж, аюулгүй хадгалах, ашиглах боломжтой байх.

### 2. АТМ, БМОМ-д тавигдах шаардлага

- 2.1. АТМ-ыг дор дурдсан санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээ хийх боломжтой байхаар тохируулах:
  - Бэлэн мөнгө авах
  - Үлдэгдэл шалгах
  - ПИН код солих
- 2.2. БМОМ-ыг дор дурдсан санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээ хийх боломжтой байхаар тохируулах:
  - Бэлэн мөнгө тушаах
  - Үлдэгдэл шалгах

- 2.3. АТМ, БМОМ-ыг үйлдлийн зааварчилгаа, дарааллыг ойлгомжтойгоор харуулдаг байхаар тохируулах.
- 2.4. АТМ, БМОМ-ын тохиргоог Монгол болон Англи хэлнээс сонгох боломжтой байхаар хийх.
- 2.5. Санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээнээс авах шимтгэлийн дүн, тайлбарыг тодорхой харуулж, карт эзэмшигч зөвшөөрсний дараа гүйлгээг дамжуулах.
- 2.6. АТМ, БМОМ дээр хийгдсэн санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээний логийг 60 хоногийн хугацаанд хадгалдаг байх.
- 2.7. БМОМ-ыг тушааж буй бэлэн мөнгөний дүнг харуулж, баталгаажуулдаг байхаар тохируулах.
- 2.8. АТМ-аас бэлэн мөнгө авах гүйлгээнд дараах шаардлагыг хангана:
  - 2.8.1. АТМ-ээс нэг удаа гарах мөнгөний хэмжээ нь тухайн үед гарах боломжит мөнгөн дүнгээр хязгаарлагдана;
  - 2.8.2. АТМ-д байгаа мөнгөн дэвсгэртийг тодорхой харуулдаг байх.
- 2.9. АТМ нь карт хураасан шалтгаан, хэрэглэгчийн үйлчилгээний төвийн хаяг, утасны дугаар бүхий баримт хэвлэж өгсний үндсэн дээр зөвхөн дараах тохиолдолд карт хурааж болно:
  - 2.9.1. Карт гаргагчаас тухайн картыг хураах хариу ирүүлсэн;
  - 2.9.2. Карт эзэмшигч буруу үйлдэл хийсэн; Жишээ нь: пин кодыг 3-аас дээш удаа буруу оруулсан
  - 2.9.3. Карт эзэмшигч үйлдэл хийхгүй 3 минутаас дээш хугацаа өнгөрсөн.
- 2.10. АТМ, БМОМ дээр хийгдэж буй санхүүгийн болон санхүүгийн бус аливаа гүйлгээний баримтыг хэвлэх эсэхийг сонгох боломжтой байх;
  - 2.10.1. Гүйлгээний баримт нь картын дугаар, гүйлгээний дүн, төрөл, давтагдахгүй дугаар (reference), тухайн АТМ, БМОМ-ын дугаар, зөвшөөрөл өгсөн дугаар, гүйлгээний огноо, цаг, трэйс дугаар зэрэг мэдээллийг агуулсан байх;
  - 2.10.2. Гүйлгээний баримт дээрх картын дугаарыг хэсэгчлэн нууцалсан байна.
- 2.11. Бүх АТМ, БМОМ-ыг камержуулсан байна:
  - 2.11.1. Камерыг гүйлгээ хийж буй карт эзэмшигчийн нүүр царай танигдахаар байршуулах;
  - 2.11.2. Боломжтой тохиолдолд бэлэн мөнгө авсан эсэхийг харуулах нэмэлт камер байршуулах;
  - 2.11.3. АТМ, БМОМ-ын камерын бичлэгийг 60 хоногоос доошгүй хугацаанд хадгалдаг байх.
- 2.12. АТМ, БМОМ-ыг тог тасрах зэрэг аливаа доголдол гарсан үед тухайн карт эзэмшигчийн хийж буй үйлдлийг бүрэн хийгдэж дуусах хүртэл үйл ажиллагаа хэвийн үргэлжлүүлэх боломжоор хангах.

### **3. ПОС-д тавигдах шаардлага**

- 3.1. ПОС-ыг дор дурдсан санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээ хийх боломжтой байхаар тохируулах;
  - Худалдан авалтын гүйлгээ
  - Буцаалтын гүйлгээ
  - Хаалтын гүйлгээ

- 3.2. ПОС дээр хийгдэж буй санхүүгийн болон санхүүгийн бус аливаа гүйлгээнд карт эзэмшигчээс шимтгэл авдаггүй байхаар тохируулах.
- 3.3. ПОС дээр хийгдэж буй санхүүгийн болон санхүүгийн бус аливаа гүйлгээнд 2 хувь баримт гаргах бөгөөд нэг нь карт эзэмшигчид, нөгөө нь КҮБ-д үлдэнэ:
- 3.3.1. Гүйлгээний баримт нь картын дугаар, гүйлгээний дүн, төрөл, давтагдахгүй дугаар (reference), зөвшөөрөл өгсөн дугаар, гүйлгээний огноо, цаг, КҮБ-ийн таних дугаар, КҮБ-ийн нэр, трэйс дугаар зэрэг мэдээллийг агуулсан байх;
- 3.3.2. Гүйлгээний баримтан дээрх картын дугаарыг хэсэгчлэн нууцалсан байна.
- 3.4. ПОС-ыг үйлдлийн зааварчилгаа, дарааллыг ойлгомжтойгоор харуулдаг байхаар тохируулах.
- 3.5. ПОС-ын тохиргоог Монгол болон Англи хэлнээс сонгох боломжтой байхаар хийх.
- 3.6. ПОС-ыг карт уншуулах үеэс эхлэн зөвшөөрөл олгосон хариуг хүлээн авах хүртэлх үе шат бүрт 20 (хорин) секундээс илүү хугацаа зарцуулах нөхцөлд автоматаар анхны төлөвт шилжиж, дараагийн төлбөрийн картыг хүлээн авахад бэлэн болдог байхаар тохируулах.